

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл: А

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар: ШуСС-2020/40

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Суурь судалгааны төслийн тайлан

2020-2023

Төслийн удирдагч:

Д.Оюунгэрэл - доктор (Ph.D), дэд
профессор. Философи, шашин
судлалын тэнхимийн багш.

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол Шинжлэх Ухааны яам

Тайлан өмчлөгч байгууллага:

Монгол Улсын Их Сургууль.

Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу,

Сүхбаатар дүүрэг. Улаанбаатар

news@num.edu.mn

Улаанбаатар

2024

СУДАЛГААНЫ БАГ:

Ч.Баярчимэг.

М.Золзаяа.

Д.Оюунгэрэл.

Төслийн удирдагч: Д.Оюунгэрэл.

МУИС-ийн ШУС-ийн ФШСТ-ийн багш доктор, дэд профессор. ("Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага" нэг сэдэвт бүтээлийн нэгдүгээр бүлэг, "Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага" бүтээлийн редактор, "Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь"-ны холбогдох ойлголт)

Гэрээт гүйцэтгэгчид:

Ч.Баярчимэг.

ХААИС-ийн Хэл соёлын тэнхимийн багш, доктор дэд профессор. ("Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага" нэг сэдэвт бүтээлийн гуравдугаар бүлэг, "Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага" бүтээлийн зохиогч, "Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь"-ны холбогдох ойлголт)

М.Золзаяа.

ШУА-ийн ФХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор. ("Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага" нэг сэдэвт бүтээлийн хоёрдугаар бүлэг, "Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь"-ны редактор, судалгааны арга зүй)

Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт	
Графикийн жагсаалт	
Зургийн жагсаалт	
I. Реферат, түлхүүр үг.	8
II. Удиртгал	10
III. Судалгааны үндэслэл	12
IV. Судалгааны зорилго, зорилт	12
V. Судалгааны арга, арга зүй.....	13
VI. Судалгааны хамрах хүрээ	14
VII. Судалгааны зохион байгуулалт	14
VIII. Судалгааны үр дүн	15
VIII.1. Нэг сэдэвт бүтээл	
VIII.2. Багш мэргэжлийн ёс зүйн зөвлөмж	
VIII.3. Эрдэм шинжилгээний хурал, семинар	
VIII.4. Эрдэм шинжилгээний илтгэлүүд	
VIII.5. Эрдэм шинжилгээний өгүүллүүд	
VIII.6. Ном товхимол	
Дүгнэлт	63
Хавсралт. 1 Судалгааны илтгэлийн жагсаалт.....	65
Хавсралт 2. Судалгааны өгүүллийн жагсаалт	67
Хавсралт 3. Төслийн явцын үр дүн ба нийгмийн соён гэгээрэл	68
Хавсралт 4. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл	69
Хавсралт 5. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	72
Хавсралт 6. Шинжээчийн дүгнэлтийн мөрөөр хийсэн засвар	78
Хавсралт 7. ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Бага чуулганы хурлын тэмдэглэлээс.....	80
Талархал	83

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
БҮТ	Боловсролын Үнэлгээний Төв
БМДИ	Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт
ЕБС	Ерөнхий Боловсролын сургууль
ИДС	Их, Дээд Сургууль
МСҮТ	Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв
МУИС	Монгол Улсын Их Сургууль
СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
ТББ	Төрийн Бус Байгууллага
ҮЭ	Үйлдвэрчний Эвлэл
ШУС	Шинжлэх Ухааны Сургууль
ШУАФХ	Шинжлэх Ухааны Академи Философийн Хүрээлэн
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Судалгаанд оролцогчдын нас

График 2. Судалгаанд оролцогчдын хүйс

График 3. Оршин буй газар

График 4. Засаг захиргааны нэгжийн багш нарын оролцоо

График 5. Багшилсан жил

График 6. Заадаг хичээлийн төрөл

График 7. Харьяалагддаг байгууллага

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Түүврийн хэмжээ

Зураг 2. Багш мэргэжлийн ёс зүй. Асуудал, хандлага нэг сэдэвт бүтээлийн хавтас

Зураг 3. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” хурлын анонс

Зураг 4. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” хурлын хөтөлбөр

Зураг 5. Олон улсын монгол судлаач эрдэмтний XII их хурлын анонс (2023).

Зураг 6. “Ёс зүй: Цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” хурлын эмхэтгэлийн нүүр

Зураг 7. “Цар тахлын үеийн багшийн үйл ажиллагаа” илтгэлийн нүүр

Зураг 8. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” хурлын эмхэтгэлийн хавтас

Зураг 9. “Цахим эрин дэх багшийн дүр төрх” илтгэлийн нүүр

Зураг 10. “Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: философи асуудлууд”. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэлийн хавтас

Зураг 12. Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэлийн нүүр.

Зураг 11. Хиймэл оюун ухааны ёс зүй: Сорилт ба хариуцлага илтгэлийн нүүр

Зураг 13. “Нийгмийн тэгш бус байдлыг дискурсив ёс зүйн үүднээс шинжлэх нь” илтгэлийн нүүр

Зураг 14. Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага. ЭШХ-ын эмхэтгэлийн хавтас.

Зураг 15. “Ёс зүйг сэтгэл судлал мэтээр ойлгохуйг залруулах нь” илтгэлийн нүүр.

Зураг 16. “Ёс зүй: Цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” эмхэтгэлийн нүүр.

Зураг 17. “Утилитарист онолын үүднээс хэрэглээний ёс зүйн зарим асуудлыг тайлбарлах нь” илтгэлийн нүүр.

Зураг 18. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” хурлын эмхэтгэлийн хавтас

Зураг 19. “Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага” илтгэлийн нүүр

Зураг 20. Бодь мөрийн зэрэг орчин үед хурлын хөтөлбөр

Зураг 21. Хэл, соёл, боловсролын тулгамдсан асуудал ОУЭШ хурлын анонс

Зураг 22. “Монголын хэвлэл мэдээлэлд багш мэргэжлийн ёс зүйн талаар туссан нь” сэдэвт илтгэлийн нүүр.

Зураг 23. Олон улсын монгол судлаач эрдэмтний XII их хурлын хөтөлбөр

Зураг 24. “To determine the ethical issues of civil servants based on several resources” илтгэлийн нүүр

Зураг 25. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. 2022 оны дугаарын хавтас, өгүүллийн нүүр

Зураг 26. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. 2023 оны дугаарын хавтас, өгүүллийн нүүр

Зураг 27. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. 2020 оны дугаарын хавтас, өгүүллийн нүүр

Зураг 28. МУИС. Философи, шашин судлал сэтгүүл. 2023 оны хавтас, өгүүллийн нүүр

Зураг 29. “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” бүтээлийн хавтас

Зураг 30. “Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь” бүтээлийн хавтас

I. РЕФЕРАТ, ТҮЛХҮҮР ҮГ

Мэргэжлийн ёс зүй бол эмчийн ёс зүй, багшийн ёс зүй, инженерийн ёс зүй, судлаачийн ёс зүй гэх мэт ажил мэргэжилтэй холбоотой ёс суртахууны асуудлыг судалдаг салбар юм. Тухайлбал, энэхүү төслийн нэгэн чухал хэсэг нь багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг тусгайлан судалсан болно.

Мэргэжлийн ёс зүй нь хувь хүний ухамсар, үнэлэмж төдийгүй, мэргэжлийн нэр хүнд, мэргэжлийн үүрэг хариуцлагыг нэгтгэдгээрээ ёс суртахууны хувьд илүү өндөр шалгуурыг шаардаж байдаг. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн ёс зүй бол ёс суртахууны шаардлага, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээний цогц. Энэ нь нэг талаас нийгмийн шаардлага, нөгөө талаас үүрэг гүйцэтгэж буй мэргэжилтний сайн дураараа хүлээсэн ёс суртахууны үүрэг юм. Мэргэжлийн ёс зүй нь судалгааны нэгэн бие даасан чиглэл болсон нь ХХ зууны үе юм.

Тухайн хүн өндөр мэдлэг чадвартай болохоос гадна мэргэжлийн ёс суртахууны хувьд хүмүүжиж төлөвших явдал чухал юм. Энэ байдлыг бодолцож, багш мэргэжлийн хөтөлбөрөөр суралцдаг оюутнуудад “Багш мэргэжлийн ёс зүй” хичээлийн хөтөлбөрийг МУИС-ийн хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 2023 оны 5 дугаар сард батлуулан 2024-2025 оны хичээлийн жилээс заахаар болов. Хувь хүний ёс суртахууны төлөвшил хүмүүжил нь улс орны нийгмийн дэвшил хөгжлийг тодорхойлогч нэг нөхцөл болдгийг үндэслэж, энэхүү хичээлийн хөтөлбөрийг суурь судалгааны төслийн хүрээнд цуглуулсан материал дээр тулгуурлан боловсруулсан болно. Түүнчлэн МУИС-ийн бакалаврын оюутнуудын сонгон судалдаг “Ёс зүйн удиртгал”, ахисан түвшний ажил мэргэжил судлалын оюутнуудын судалдаг “Зөвлөх мэргэжлийн ёс зүй” хичээлд энэхүү төслийн үр дүнд хэвлэгдсэн бүтээлүүд хичээлд ашиглах нэгэн чухал үр дүн болов.

Хөгжингүй болон хөгжиж байгаа улс орнуудын боловсролын бодлогод хүний хөгжлийн асуудал, ялангуяа хүний хөгжилд ёс суртахууны асуудал, мэргэжлийн ёс зүйн асуудал чухал байр суурь эзэлдэг. Ямар ч мэргэжилтэн сургуулиа төгсөөд нийгэм, хамт олны дунд ажиллаж амьдардаг. Тэд хүмүүсийн дунд амьдарч, ажиллаж, бүтээж буй хөдөлмөр нь өөрийнхөө төдийгүй бусад хүний сайн сайхны төлөө, нийгмийн сайн сайхны төлөө байх ёстойг ухаарах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийн учир утга, ач тусыг тооцоолон гүйцэтгэв.

Манай улсын хувьд мэргэжлийн ёс зүйн мэдлэг, чадвар олгох, хандлагыг төлөвшүүлэх явдал чухал болоод байна. Бид энэхүү суурь судалгааны ажлын хүрээнд мэргэжлийн ёс зүйн асуудлыг судалж, тэр дундаа багш мэргэжлийн ёс зүйг

сонгон, онолын болон практикийн талаас шинжилж, эрдэм шинжилгээний бүтээл туурвих ажлыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл нар “Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” 10 хх бүхий нэгэн сэдэвт бүтээл, Ч.Баярчимэг “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” 12.5хх бүтээл, Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл нар бичиж, М.Золзаяа редакторлан “Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь” зэргийг олон нийтийн хүртээл болгов.

Суурь судалгааны хүрээнд “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” /2022/ эрдэм шинжилгээний хурлыг улсын хэмжээнд МУИС дээр зохион байгуулав. Тус хурал нь 4 дэд салбар хуралдааны хүрээнд 8 байгууллагын 23 судлаач 14 илтгэлийг ганцаарчлан болон хамтран хэлэлцүүлэв. Мөн эрдэм шинжилгээний дотоодын болон гадаадын 13 хуралд илтгэл хэлэлцүүлж, 4 өгүүллийг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүллээ.

Төслийн үр дүнгээс сурталчлах ажлыг төслийн багийн гишүүд гүйцэтгэсэн болно. Тухайлбал, төслийн судлаач М.Золзаяа мэргэжлийн ёс зүй, ажлын байрны ёс зүйн тухай мэдлэг, ойлголтыг лекцээр дамжуулан нийт 550 орчим хүнд хүргэжээ. Төслийн удирдагч Д.Оюунгэрэл багш мэргэжлийн ёс зүйн чиглэлээр ЮНЕСКО-той хамтран ёс зүйн багш нарт 3 удаагийн сургалт, мөн байгууллага хамт олонд ажлын байрны ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн талаар сургалт хийв.

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Эрдмийн зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар “Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” төслийн үр дүнд гүйцэтгэсэн ажлуудыг танилцуулж, зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар тус төслийг амжилттай хэрэгжүүлсэн хэмээн санал нэгтэй дэмжсэн болно.

Түлхүүр үг. Ёс зүй, ёс суртахуун, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, үүрэг хариуцлага, нэр хүнд, чадвар, харилцааны ёс зүй.

II. УДИРТГАЛ

XXI зуун бол боловсролын зуун. Боловсрол бол хүний амьдарч аж төрөх арга хэрэгсэл, хүний эдлэх ёстой эрх тул хүн бүр түүний бүх боломжийг тэгш хэрэглэж, үр ашгийг шударгаар хүртэх нь чухал юм. Энэ дан ганц мэргэжлийн мэдлэг чадварыг эзэмших төдийгүй мөн ёс зүйн мэдлэг, чадвар, хандлагын тухай цогц асуудал билээ.

Аливаа нийгэм хөгжих үү, эс хөгжих үү гэдэг нь мэргэжилтний мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүйн төлөвлөөс хамаарна. Тухайлбал, багш мэргэжлийн нэр хүнд өндөр, үлгэр дуурайл сайн байх нь боловсролын салбарын хөгжлийн нэг гол нөхцөл төдийгүй нийт нийгмийн харилцааг зохицуулагч, чиглүүлэгч нэг арга хэрэгсэл билээ. Өнөөгийн монгол хүний хөгжил, нийгмийн харилцааг боловсронгуй болгоход мэргэжлийн ёс зүйн мэдлэг чадвар, мөн үлгэр дуурайл чухал үүрэгтэй. Учир нь ёс зүйн боловсрол нь хувь хүний хөгжилд, түүний мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилд шийдвэрлэх ач холбогдолтой. Тухайлбал, бид энэхүү төслийн хүрээнд багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг тусгайлан судалсан нь санамсаргүй хэрэг биш гэдгийг 2022 оныг БШУЯ-аас салбарын ёс зүйн жил болгон зарласан явдал нотлон харуулсан юм. Сүүлийн жилүүдэд багшийн ёс зүйн асуудал нийгэмд багагүй шуугиан дэгдээж, эцэг эх, багш сурагчдыг төдийгүй нийт нийгмийг бухимдуулах явдал тохиолдох боллоо. Энэ нь манай улсын боловсролын шинэчлэлийн үйл явцад багшийн ёс зүйн асуудлыг судалж, таниулах хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Манай улсад социологийн болон боловсрол судлал, ёс зүйн судалгааны өгүүлэл, илтгэлүүдэд багш мэргэжлийн нийгмийн байр суурь, нэр хүндийн талаарх практик асуудлуудыг нэлээд авч үзсэн байна. Тухайлбал, зарим бүтээлд нийгэмд багшийн нэр хүндийг унагаж буй үйл явдлын жишээ, тоо баримтыг дурдаж, хэрхэн шийдвэл зохистой болох талаар санал, дүгнэлтийг дэвшүүлжээ. Олон улсын түвшинд багш мэргэжлийн нэр хүндийн тухай судалгааны аргачлалд олон нийтийн үнэлгээ, суралцагчид, эцэг эхийн эсвэл тухайн мэргэжилтний бүлгийн үнэлгээг тус тусад нь авч үзээд харьцуулах хандлага голложээ.

Бид багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдлын талаар 1493 багшаас социологийн судалгаа авч, түүнд тулгуурлан нэгэн сэдэвт бүтээл туурвисан нь хүч хөдөлмөр зарсан, хэрэглээний хувьд судлаач, олон нийт, оюутан суралцагч хэн бүхэнд тодорхой ойлголт өгөх бүтээл болсноороо ач холбогдолтой. Мөн

түүнчлэн мэргэжлийн ёс зүйн онолын болоод гадаад дотоодын туршлагыг харьцуулан судалсан “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” бүтээлийг тус төслийн хүрээнд эрхлэн гаргасан нь манай судалгааны нэгэн чухал үр дүн болсон. Тус бүтээл нь мэргэжлийн ёс зүйн тодорхой чиглэлүүдийг тайлбарласан нь сургалт судалгааны шинэлэг, ач холбогдолтой юм.

Төслийн багаас мэргэжлийн ёс зүйн нэр томъёоны товч тайлбар толийг хэвлүүлж байгаа нь мэргэжлийн хийгээд хэрэглээний ёс зүйн салбарын нэр томъёо судлалд чухал ач холбогдолтой болж байна.

III. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Ёс зүй нь норматив, мета, хэрэглээний ба мэргэжлийн гэсэн гурван чиглэлээр хөгжиж ирэв. Аль ч чиглэл нь чухал бөгөөд хувь хүний болон нийгмийн хөгжлийг тодорхойлох чухал хүчин зүйл байсаар ирсэн, байсаар байна, байсаар байх болно.

Мэргэжлийн ёс зүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, хандлагыг төлөвшүүлэх асуудал аливаа улс орны хөгжлийн чухал асуудал мөн. Учир нь мэргэжлийн ёс зүйн зөрчил даамжирвал салбарыг бүхэлд нь ганхуулдаг. Өнөө үед манай улсад мэргэжлийн мэдлэг чадварын дутагдал их байна уу, мэргэжлийн ёс зүйн зөрчил дутагдал их байна уу хэмээн асуувал ёс зүйн зөрчил их буй нь олон зүйлээс харагдаж байна. Тиймээс бид энэхүү сэдвийг сонгож авсан бөгөөд бүгдийг биш ч тодорхой нэг асуудлыг ул суурьтой судлахыг зорьсон билээ. Багш мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг социологийн судалгаанд тулгуурлан илрүүлж, судалгааны үр дүнг онолын үүднээс тайлбарлах, улмаар судлаач, олон нийт оюутан сурагчдад гарын авлага болох бүтээл туурвих нь нэн чухал хэрэгцээт ажил болох юм.

IV. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Мэргэжлийн ёс зүйн тэр дундаа багш мэргэжлийн ёс зүйн төлөвшил, өөрчлөлт, нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлс, тулгамдсан асуудал, цаашдын хандлагыг тайлбарлаж, шаардлагатай шинжлэх ухааны үндэстэй бүтээл туурвихад оршино. Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Бид энэхүү судалгааны ажилдаа багшийн ёс зүйн асуудлыг онцолж, социологийн судалгаанд үндэслэн өнөөгийн монголын багшийн харилцааны ёс зүй, соёл, багшийн нийгмийн дүр төрх, багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг хариуцлагыг судалж, тулгамдсан ямар асуудал буйг тодруулах, нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх,
2. Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлагыг мэргэжлийн ёс зүйн судалгааны тойм болон мэргэжлийн ёс зүйн зарим чиглэлийн онол, практикийн мэдлэг дээр үндэслэн тайлбарласан бүтээл хэвлүүлэх,
3. Мэргэжлийн ёс зүйн талаар судалгаа явуулдаг, мөн суралцагч нарт тулгамдсан нэг асуудал бол нэр томьёог тайлбарласан бүтээл хомс байдаг явдал. Тиймээс бид суурь судалгааны хүрээнд мэргэжлийн ёс

зүйн нэр томъёоны тайлбар толь бичих

4. Мэргэжлийн ёс зүйн өгүүлэл хэвлүүлэх, илтгэл хэлэлцүүлэх, сурталчлах зэрэг болно.

V. СУДАЛГААНЫ АРГА, АРГА ЗҮЙ

Шинжлэх ухааны судалгаанд өргөн хэрэглэгддэг ерөнхий болон социологийн судалгааны аргыг ашигласан болно.

Тус төслийн судалгааны ажилд ашигласан ёс зүйн судалгааны арга зүйн заримаас дурдвал:

- Ёс суртахууны сонголтын нийгмийн нөхцөл байдлыг шинжлэх
- Хэсэгчилсэн тохиолдол шинжлэх
- Танин илрүүлэх үе шатны ажиглалт хийх
- Мэргэжлийн онцлог, хандлагын хамаарлыг шинжлэх зэрэг арга голлох үүрэгтэй байв.

Социологийн судалгааны арга: анкет, чанарын судалгааны ярилцлагын арга байв.

Тоон судалгааны арга зүй: Анкетийн арга, судалгааны тоон мэдээлэлд шинжилгээ хийх аргыг ашиглаж, дүгнэлт хийсэн. Эксперт болон мэргэжилтнүүдээс анкетийн аргаар мэдээлэл цуглуулсан. Асуулгыг боловсруулахад хамаарагч, үл хамаарах, дэмжигч, дамжуулагч хувьсагчуудыг тооцож, судалгаанд тоон төлөөлөл (representativity), мэдээллийн үнэн магадлалын байдал (validity), мэдээллийн найдвартай чанар (reliability) гэсэн гурван шалгуурыг хангаж ажиллав. Анкет нь нийт 56 асуулттай байв.

Чанарын судалгааны арга зүй: Ярилцлагын болон баримт бичгийн шинжилгээний аргыг “Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” нэгэн сэдэвт бүтээлд судлаачид ашиглаж, дүгнэлт хийв.

Баримт бичгийн шинжилгээний арга: Судалж буй асуудалтай холбогдох судалгааны тайлан, мэргэжлийн ном, сурах бичиг, толь бичиг, бодлого, эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжид агуулгын шинжилгээ хийсэн. Тухайлбал, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн талаар өмнө хийгдсэн судалгааны үр дүн, статистикийн мэдээ баримтыг судлан дүн шинжилгээ хийсэн болно.

Шинжилгээг дараах баримт бичгийн хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Байгууллагын дотоод журам болон мэргэжлийн ёс зүйн дүрмүүд,

- Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, ХЭҮК-ын тайлангууд;
- Холбогдох хууль, тогтоомж;
- Эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон интернэтийн мэдээ, мэдээлэл гэх мэт.

Судалгааны мэдээлэл боловсруулалт: Тоон судалгааны мэдээллийг боловсруулах, шинжилгээ хийхэд нийгмийн судалгаанд түгээмэл хэрэглэгддэг статистик шинжилгээ хийх багц программ болох SPSS 20.0 программыг ашиглан, мэдээллийн шинжилгээний боломжит үр дүнгүүд, тухайлбал тайлбарлах болон харьцуулсан статистикийн үр дүнг боловсруулан тайланг зохих газарт нь хүргүүлсэн. Мөн МУИС-ийн номын санд хүргүүлсэн. Мөн чанарын судалгааны ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргаар цуглуулсан анхдагч мэдээллийг нэгтгэн боловсруулж, үр дүнг тайланд тусгаж ажиллав.

VI. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Монголын багш нарын мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдлын талаарх социологийн судалгааг хийхдээ боловсролын бүх шатны багш нарын төлөөллийг хамруулахыг зорьсон. Түүврийн объектийн сонголт хийхдээ хүн амын төвлөрөл, суурьшил, нутаг дэвсгэрийн бүсчлэл, мэргэшлийн байдал зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэв.

VII. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгаа 2020-2023 онд гурван үе шаттай байв. Нэгдүгээрт мэргэжлийн ёс зүйн чиглэлээрх сүүлийн үеийн онолын судалгааны бүтээлүүдийг судлав.

Хоёрдугаарт, мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг тодорхойлж, учир шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тайлбарлах судалгаа хийж, судалгааны үр дүнг системчлэн нэгтгэж, тайлан, судалгаанд суурилсан онолын тайлбартай нэг сэдэвт бүтээл туурвив.

Гуравдугаарт, судалгааны асуудлын талаар томъёолсон, онолын дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох талуудтай хэлэлцүүлэг хийх, хэвлэн нийтлэх зэрэг байв.

VIII. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

VIII.1. Нэг сэдэвт бүтээл

“Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага”

нэг сэдэвт бүтээл

“Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” төслийн хүрээнд нэг сэдэвт бүтээл туурвих ажлыг үр дүнгийн даалгаварт тусгасаны дагуу “Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” нэгэн сэдэвт бүтээлийг “Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал” социологийн судалгааны тайланд үндэслэсэн бичив.

Багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлах ажлын хүрээнд ИДС, ЕБС, СӨБ зэрэг байгууллагын нийт 1493 багшийг хамруулан судалсан болно.

Социологийн судалгааны тоймоос танилцуулбал:

Судалгааны түүврийн хүрээ: Судалгааны нэгжийг сонгохдоо хэд хэдэн үе шаттайгаар сонгох буюу үе шат бүхэнд түүврийн нэгж хэвээр хадгалагдаж, харин түүврийн хэмжээ эх олонлогоосоо хамаарч өөр өөр байхаар тооцсон. 21 аймаг, 9 дүүргийн гурван шатны боловсролын байгууллагын үндсэн багш нараас энгийн санамсаргүй түүврийн арга ашиглан судалгаанд хамруулахаар тооцоолсон. Түүврийн зохистой хэмжээг тогтоохдоо сонирхон судалж буй асуудалд бодитой нөлөөлөх хүчин зүйлүүд болох оролцогчдын нас, хүйс, ажил эрхлэлт, хаяг байршил зэрэг нийгэм, хүн ам зүйн гол үзүүлэлтийг ашигласан

Түүврийн хэмжээ


Determine Sample Size	
Confidence Level:	<input checked="" type="radio"/> 95% <input type="radio"/> 99%
Confidence Interval:	<input type="text" value="2.5"/>
Population:	<input type="text" value="52160"/>
<input type="button" value="Calculate"/> <input type="button" value="Clear"/>	
Sample size needed:	<input type="text" value="1493"/>

Зураг 1. Түүврийн хэмжээ

Судалгаанд хамрагдах 3 шатны боловсролын байгууллагад нийт 52160 үндсэн багш ажиллаж байна. Түүврийн хэмжээ буюу респондентийн тоог тооцоходоо 95 хувийн итгэх түвшинтэйгээр 2.5 хувийн алдааны хязгаартайгаар 1493 респондент судалгаанд хамрагдахаар тооцоолол гарсан.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2020 оны 01 дүгээр сараас 04 дүгээр сарыг хүртэл, 2022 оны 02 дугаар сараас 04 дүгээр сар хүртэл онлайнаар гүйцэтгэсэн. Нийт 1493 хүнийг хамруулан судалгааг авч, боломжтой өгөгдлүүдийг ашиглан судалгаанд оролцогчдын статистик мэдээллийг SPSS 22.0, Excel програмуудыг ашиглан боловсруулалт хийж, үр дүнг нэгтгэсэн. Өгөгдлийг боловсруулахдаа тайлбарлах, нэгтгэн дүгнэх аргыг ашиглав.


График 1. Судалгаанд оролцогчдын нас



Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзэхэд 30-39 насны багш нар 34.3 хувь, 20-29 насны 26.1 хувь, 40-49 насны багш 26.6 хувь, 50-иас дээш насны багш нар 13 хувь эзэлсэн. Бүх насны багш нарыг оролцуулах зорилго тавьж ажилласан. Их дээд сургуульд 16 настай элсэгчийн тоо ихэссэн тул ажлын талбарт 20 наснаас эхлэн гарах магадлалтай тул 20-29 насны ангилал оруулсан болно.

Судалгаанд оролцогчдын насыг харахад дийлэнх нь эмэгтэй багш нар оролцжээ.

График 2 Судалгаанд оролцогчдын хүйс



13%




87%

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежийн нийт үндсэн багшийн тоо 52160 бөгөөд үүний 42256 нь эмэгтэй багш^[1] (Хороо, 2021) байдаг аж. Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн нийт 35110 багш нарыг хүйсний харьцаагаар авч үзэхэд эрэгтэй багш 6488, эмэгтэй багш 28642^[2] (хороо, 2022) ажээ. Энэхүү судалгаанд оролцогчдын 87 хувь эрэгтэй, 13 хувь эмэгтэй оролцогч байлаа.

Судалгаанд оролцогчдыг оршин суугаа газрыг хүснэгтээр харуулбал:

График 3. Оршин буй газар



[1] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.


https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2002_067V1&CS003_select_all=0&CS003SingleSelect=_1_11&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table2022.05.01

[2] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2002_067V1&CS003_select_all=0&CS003SingleSelect=3_31&YearY_select_all=0&YearYSingleSelect=2021&viewtype=piechart.2022.05.01


Аймаг, сум, нийслэл гэсэн үзүүлэлтээр судалгаанд оролцогчдыг сонгож, асуулт илгээсэн бөгөөд орон нутгийн багш нараас судалгаанд түлхүү оролцуулсан. Улаанбаатар хотоос 40.8 хувь, аймгийн төвөөс 15.3 хувь, сумдаас 43.9 хувьтай оролцлоо.

График 4. Засаг захиргааны нэгжийн хувьд багш нарын оролцоо



Судалгаанд оролцогчдын 83.3 хувийг ерөнхий боловсролын сургуулийн багш нар, 3.7 хувийг их, дээд сургуулийн багш 13 хувийг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нар эзэлсэн. Сургалтын төвийн багш нарыг хамруулсан судалгаа бага тул оролцуулах зорилт тавьсан ч МСҮТ болон сургалтын төвийн багш нарын онлайн судалгаанд оролцох идэвх хангалттай бус байлаа.

График 5. Багшилсан жил



Судалгааг голчлон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг оролцуулах зорилго тавин ажилласан. Нийт оролцогчдын дунд эзлэх хувь 80-аас дээш хувь байхаар тооцсон. Нийт оролцогчдын 83.3 хувь нь ЕБС-аас, их дээд сургуулиас 13.1 хувь, сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас 3.7 хувь нь оролцлоо. МСҮТ-ийн багш нарт асуулга явуулсан боловч оролцоогүй бөгөөд төвөөс 0,1 хувь оролцсон.

Ажилласан жилийн хувьд 0-5 жил ажилласан багш 30.5 хувь байсан бөгөөд бусад оролцогч нар 6-аас дээш жилийн ажлын дадлага туршлагатай багш нар оролцдог.

График 6. Заадаг хичээлийн төрөл





График 7. Харьяалагддаг байгууллага



Социологийн судалгаа нь багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг онцолсны үндсэн дээр өнөөгийн монголын багшийн харилцааны ёс зүй, соёл, багшийн нийгмийн дүр төрх, багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг хариуцлагыг судалж, тулгамдсан ямар асуудал буйг тодруулах зорилго тавьсан.

Ийнхүү судлаачид хариуцсан бүлэг бүртээ социологийн судалгааны үр дүнгээс тоочин дүгнэлт хийсэн тулд энд тэр бүхнийг дэлгэрэнгүй оруулах шаардлагагүй гэж үзлээ. Түүнчлэн ажлын тайланг тухай бүрт ШУТС-д хүлээлгэн өгч байсан болно.

“Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” бүтээл нь гурван бүлэг, 10 хэвлэлийн хуудастай бөгөөд редактороор МУИС-ийн багш профессор Г.Эрдэнэбаяр ажиллав.

Бүтээлийн “Багш мэргэжлийн ёс зүйн үндэс” 1-р бүлгийг Дашдоржийн Оюунгэрэл, “Багш мэргэжлийн нэр хүнд, хариуцлага” 2-р бүлгийг доктор Мөнхцэрэнгийн Золзаяа, “Өнөөгийн нийгэм дэх багш” 3-р бүлгийг Чулууудайн Баярчимэг нар тус тус бичив.

Нэгдүгээр бүлэгт багш мэргэжлийн ёс зүйн тухай, багшийн харилцааны ёс зүй, соёлын асуудлыг нийгмийн эрэлт хэрэгцээтэй, хоёрдугаар бүлэгт багш мэргэжлийн нэр хүнд, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг шинжилж, багш мэргэжлийн үүрэг хариуцлагыг, гуравдугаар бүлэгт багшийн нийгмийн дүр төрх, цахим орчин дахь багшийн ёс зүйн талаарх үнэлэмжийг тус тус тодруулан авч үзсэн болно.

Эдгээрийг бүлэг тус бүрээс нэгтгэн дүгнэвэл:

Багшийн мэргэжил бол түүнээс ёс зүйн мэдлэг, чадвар, зөв төлөвшил илүү шаарддаг онцгой мэргэжил юм. Багшийн харилцааны чухал хүрээнд бол оюутан суралцагч, тэдний гэр бүл, мөн хамт олон зэрэг багтдаг. Өнөө үед харилцааны соёл, чадвар улам бүр ач холбогдолтой болж байна. XXI зуунд харилцааны ур чадварыг чухалчлах болсон бөгөөд “Өөрийгөө чухалчлахдаа гол бус бусдыг мэдрэх” чухал хэмээн үзэх болсныг дүгнэлтэд дахин онцолж дурдав. Багш нарын дунд ёс зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, мөн тэдний хоорондын харилцаанд асуудал байдаг болохыг судалгаанд оролцогчид илэрхийлжээ. Тиймээс ёс суртахуунтай багшид байх (харилцааны соёл, харилцах эв дүй, хүний оронд өөрийгөө тавьж боддог, өөрийгөө бүх юмны төв гэж үзэлгүй хүнлэг даруу байх, өөрийгөө зөв ойлгуулж, бусдыг зөвөөр ойлгодог гэх мэт) суурь чадваруудыг сургалт хийх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан үргэлж хүргэж байх шаардлагатай.

Хүмүүсийн харилцах тодорхой хэм хэмжээн дээр харилцааны соёл бий болдог. Багшийн ёс зүй, харилцааны соёлын онцлог нь бусад мэргэжлийнхээс илүү өндөр түвшинд байхыг шаарддаг бөгөөд энэ нь нийгмийн хөгжлийн ач холбогдолтой. Багш мэргэжлийн зорилгодоо хүрэх нэгэн чухал хэрэглүүр бол түүний харилцааны чадвар болно. Багш бол харилцааны ёс зүйн хувьд нийгмийн бусад төлөөлөлд үлгэр дуурайл үзүүлэхүйц түвшинд хүрч соёлжиж боловсорсон байдаг, байх ч ёстой. Тиймээс багш хүн бол бие биедээ болон шавь нартаа үлгэр дуурайл үзүүлж, хүндэтгэл хүлээсэн хүн байх болохоос бус тэдэнтэй зүй бус харилцаж, үг хэл, үйлдлээр толхилцож суух хүн биш. Багшийн зохисгүй харилцаа нь түүний ёс зүйн боловсролыг харуулна. Багш хүн мэдлэг чадвар, харилцаа хандлагаараа шавь нартаа үлгэрлэж, бусдыг манлайлагч байна гэдгийг тус нэг сэдэвт бүтээлийн нэгдүгээрт бүлэгт судлан дүгнэжээ.

Тус бүтээлийн хоёрдугаар бүлэгт багш мэргэжлийн хариуцлага, нэр хүндийн тухай асуудлыг тал бүрээс нь авч үзсэн. Үүнд, мэргэжлийн ёс зүй нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааны ёс суртахууны хэм хэмжээг төлөвшүүлж, ёс суртахууны зөв сонголт хийх арга замыг судалдаг хэрэглээний ёс зүйн салбар. Тухайлбал, багш мэргэжлийн ёс зүй нь боловсролын салбарын хөгжилд хувь нэмэр оруулах ач холбогдолтой. ЮНЕСКО-гийн Боловсролын нийгмийн шинэ гэрээнд багш нар бол хамтын хүчин зүтгэлээрээ боловсрол, нийгмийн өөрчлөлтийг бий болгох шинэ мэдлэгийг сэдэлжүүлэх хүч гэж үзсэн билээ. Багш нь өөрийн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлж, олон нийтийн итгэлийг хүлээх,


насан туршид суралцах замаар мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлж байх, суралцагчийн сайн сайханд нөлөөлөх бүхий л үйл хэрэгт анхаарал тавих; суралцагчийн сайн сайхны төлөө найз нөхөд, эцэг эх, асран хамгаалагчтай нь зөвлөлдөх эрхтэйг хүлээн зөвшөөрөх зэрэг үүрэг хүлээнэ гэдгийг онцолж дурдсан. Багшийн хариуцлага нь боловсролын салбарын ахиц дэвшлийн хүчин зүйл юм.

Багш мэргэжлийн нийгмийн үнэлэмж буурах шалтгааныг тодруулж, энэ нь тэдний цалин хөлс, урамшууллын тогтолцооноос гадна мэргэжлийн ёс зүйн түвшинтэй ихээхэн холбоотой буйг судлаач дэвшүүлсэн тавьсан. Иймд боловсролын салбарын оролцогч талууд багш мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэхэд анхаарч, багш нарын тасралтгүй хөгжих эрэлтийг хангасан бодлого хэрэгжүүлэх нь улмаар манай иргэдийн боловсролын чанар, нийгмийн хөгжилд эрс өөрчлөлт авчрах гол хөшүүрэг юм. Багш бол суралцахуйн дизайнер гэж үзэх болсон өнөө цагт манай багш нар багшлахуйн мэдлэг, боловсролоо тогтмол дээшлүүлэхийг хичээн ажиллаж байна. Ер нь багшийн хөгжлийн асуудал нь тэдний ажлын үр дүнгээр хэмжигдэх болно. Олон нийтийн анхаарлыг татаж буй багшийн ёс зүйн тулгамдсан асуудлыг засаж залруулахын тулд ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох, байгууллагын эрхэм зорилгод ёс суртахууны үнэт зүйлсийг тусган энэ талаар сургалт, семинарыг тогтмолжуулах нь үр дүнтэй. Мөн багш бэлтгэх явцад мэргэжлийн утга учир, үнэ цэнийг танин мэдэж итгэл үнэмшил болгох чухал юм. Зарим оронд багшийн мэргэжлийг нийгмийн зүгээс чухал хэрэгцээт мэргэжилд тооцон тэднийг бүхий л боломжоор хангадаг нь багшийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд нэмэгдэх нөхцөл бүрдүүлдэг туршлагаас нэвтрүүлэх шаардлагатай талаар судалж дүгнэлт гаргасан байна.

Гуравдугаар бүлэгт XX зууны багш өөрийн мэдлэгээ суралцагчдад дамжуулан заадаг байсан бол XXI зууны багш суралцахуйг хөтлөгч, сурахуйг дэмжигч болон өөрчлөгдлөө. Багшийн үүрэг нь хичээл заахаас гадна хүмүүжлийн ажил давхар эрхэлдэг. Багштайгаа өнгөрүүлэх цаг их тул асран хамгаалагчийн үүрэг давхар гүйцэтгэдэг. Багш нар суралцагчиддаа, ялангуяа гэр бүлийн нөхцөл муу хүүхдүүдэд эерэг үлгэр дууриал үзүүлэх загвар болдог. Багш мэргэжлийн нэр хүндийг өргөж, чанар, чадварыг сайжруулахын тулд багшийн цалин, хөлсийг нэмэгдүүлэх, элсэгч оюутныг дэмжих бодлого хэрэгтэй байна. Зарим мэргэжлийн багшийн хүрэлцээ хангалтгүй байна. Цаашдаа хөдөө, орон нутаг өөрийн бодлогоор багшаа бэлтгэж авахын тулд элсэгчээ дэмжих шаардлага үүснэ.

Боловсролын байгууллагын багштай холбоотой алдаа дутагдлын талаархи маргаантай асуудлуудын нэг нь ёс суртахууны хэм хэмжээг мөрдөх явдал юм. Боловсролын байгууллагын багштай холбоотой алдаа дутагдлын талаарх маргаантай асуудлуудын нэг нь ёс суртахууны хэм хэмжээг мөрдөх явдал юм. Багшийн мэргэжлийн үүрэг нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үр дүнг урьдчилан харж, түүнийг хариуцах чадвар, хүсэл эрмэлзэлтэй байх юм. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь тухайн улсын нийгэм эдийн засаг, соёл иргэншил, иргэдийн боловсрол, соёлын түвшингөөс шалтгаалан хамаарч эргэх холбоотой байдаг. Нэгдмэл нэг бодлого нь суралцахуйн ололт амжилтыг багштай холбоотой бүх тодорхойлогч хүчин зүйлстэй уялдуулан авч үзсэн шийдлүүдтэй байх хэрэгтэй. Үүнд, ажилд авах шалгаруулалт, багш бэлтгэх сургалт, тэнцвэртэй хуваарилан байршуулалт, мэргэжлийн тасралтгүй хөгжил, зохистой цалин хөлс, карьерын хувьд ахиж дэвших боломж, ажиллах орчин бүрдүүлэлт зэрэг багтана. Багш нарыг ажилд авах, үйл ажиллагааг нь тогтмол үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх тохиолдолд тэдний мэдлэг чадвар, чадамжийн түвшинг харгалзан үзэх ёстой. Сургуулийн болон нэгжийн удирдлагууд тухайн салбарын эсвэл хөтөлбөрийн профессор, багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх хэрэгцээг тогтоох, нөөц бололцоог олж илрүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Зураг 2. “Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” бүтээлийн хавтас



VIII.2. Багш мэргэжлийн ёс зүйн зөвлөмж

“БАГШ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ” ЗӨВЛӨМЖ

Багш мэргэжлийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай.

Үүнд:

1. Багш бэлтгэдэг их дээд сургуулиас багш мэргэжлийн ёс зүйн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй, үндэсний онцлогийг харгалзан, уламжлал, шинэчлэлийг хослуулан хийх;
2. Багш бэлтгэх тогтолцоог сайжруулах, багш бэлтгэх явцад ёс зүйн болон мэргэжлийн ёс зүйн мэдлэгийг чанартай олгох;
3. Багш мэргэжлийн ёс зүйн мэдлэг, ёс суртахууны харилцаа, хандлагыг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах;
4. Ёс зүйн мэдлэг, мэргэжлийн ёс зүйн талаарх мэдээллийн түгээх, сурталчлах давтамжийг нэмэгдүүлэх;
5. Сургуулийн веб сайтад ёс зүйн боловсролын чиглэлээр мэдээ, мэдээлэл тогтмол байршуулах;
6. Боловсролын байгууллагууд багш мэргэжлийн ёс зүйн сургалтын хөтөлбөр, гарын авлага, зөвлөмжийн материалуудтай байх, мэргэжлийн ёс зүйн болон хүний нөөцийн сургалтын зардлыг байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлэх;
7. Бусад орны багш мэргэжлийн ёс зүйн талаарх мэдлэгийн түвшин тогтоох арга, туршлагаас өөрийн орны онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх;
8. Багшийн ёс зүйн дэд хороо нь мэргэжлийн нэр хүнд, үүрэг хариуцлагаа эрхэмлэх явцад эргэлзээтэй асуудал үүсвэл зөвлөгөө өгөх чадамжтай байх шаардлагатай.
10. Багшийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах талаар санаачилгатай ажиллах.

VIII.3 Эрдэм шинжилгээний хурал, семинар

“Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” төслийн үр дүнгийн даалгаварт хурал зохион байгуулах ажлыг тусгасан билээ. Энэ ажлын хүрээнд эрдэм шинжилгээний хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр МУИС, ШУТИС-ийн БуХС болон “Нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцахуй” ТББ-тай хамтран зохион байгууллаа. Нэг төслөөр бүх мэргэжлийн ёс зүйн асуудлыг судлах боломжгүй тул багш мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг судлах зорилго тавьсан болно. Энэ нь цаг үеэ олсон чухал сэдэв байсныг БШУЯ-аас 2022 оныг салбарын ёс зүйн жил болгон зарласан явдал нотолсон юм.

Ёс зүйн хурлыг “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” гэсэн ерөнхий сэдвийн дор:

- 1) Боловсролын ёс зүй,
- 2) Ирээдүйн ардчилал, ёс зүй,
- 3) Хүйс, жендэр, ёс зүй,

4) Дижитал шилжилтийн төвд хүнийг тавихуй гэсэн дэд сэдвийн хүрээнд илтгэлүүд хэлэлцүүлсэн. Боловсролын ёс зүй дэд салбар хуралдаанд багш мэргэжлийн ёс зүйд холбогдох асуудлуудыг эрдэмтэн судлаачид хэлэлцүүлсэн болно. Тухайлбал, “Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага”, “Цахим эрин дэх багшийн дүр төрх”, “Их сургууль ёс зүйн боловсролын төв болох нь”, “Монгол Улсын боловсролын салбар дахь ёс зүйн тулгамдсан асуудлууд”, “Академик орчин дахь их сургуулийн багшийн ёс зүйн асуудал: Олон улсын баримт бичгүүдэд хийсэн анализ”, “Монголын их дээд сургуулийн ёс зүйн дүрэмд хийсэн системийн шинжилгээний үр дүн”, “Багшлахуйн менежмент ба ёс зүй” зэрэг илтгэл мэргэжлийн ёс зүйн асуудлыг хөндөж, шийдэх арга замыг хэлэлцүүлсэн болно.

Зураг 3. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд”
хурлын анонс

АЙСУЙ ХҮН:
Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд
Улсын хэмжээний ёс зүйн эрдэм шинжилгээний IX хурал

Дэд сэдэв	Илтгэл хүлээн авах	Хэзээ, хаана	Зохион байгуулагч
<ul style="list-style-type: none"> • Боловсролын ёс зүй • Ирээдүйн ардчилал, ёс зүй • Хүйс, жендэр, ёс зүй • Дижитал шилжилтийн төвд хүнийг тавихуй 	<p>Илтгэлийг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны дотор prs.num42@gmail.com хаягаар хүлээн авна.</p>	<p>Хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр МУИС-ийн Номын сангийн 502 тоот танхимд зохион байгуулна.</p>	<p>МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим ШУТИС, Бизнес Хүмүүнлэгийн Ухааны Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Салбар “Нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцахуй” ТББ</p>

Холбоо барих
99003188
88820660
prs.num42@gmail.com

Илтгэлд тавигдах шаардлага

1	2	3	4
<p>Илтгэлийг өмнө хэвлээгүй, өөр хуралд хэлэлцүүлээгүй байх</p>	<p>Илтгэл нь дараах хэсэгтэй байна. Илтгэлийн нэр, илтгэгчийн овог, нэр, ажил, албан тушаал, эрдмийн зэрэг, цол, харилцах утас, хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, эшлэсэн бүтээл</p>	<p>Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, оршил, текст, зураг (график болон фото зураг), хүснэгт, дүгнэлт, эшлэлийг оролцуулан А4 хэмжээтэй 5-7 хуудас байна.</p>	<p>Илтгэлийг зөвхөн UNICODE ашиглаж, “Times New Roman” фонт дээр 12 pt үсгийн өндрийг сонгон, мөр хоорондын зай 1 байх, А4 хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод, баруун талаас 2,5 см, зүүн талаас 3 см зайг үлдээж бичнэ. Эшлэл, ном зүйг АРА загвараар хийнэ.</p>

Холбоо барих
99003188
88820660
prs.num42@gmail.com

Зураг 4. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд”

хурлын хөтөлбөр

АЙСУЙ ХҮН: ДАЯН ДЭЛХИЙН ШИЛЖИЛТ ДЭХ ЁС ЗҮЙН СОРИЛТУУД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР	
9:00	НЭЭЛТ ҮДЭЭС ӨМНӨХ ХУРАЛДААН - НЭГ Хуралдааны дарга: Доктор (Ph.D), профессор Б.Дагзмаа
9:15	“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт зарим эргэцүүлэл Доктор (Ph.D), профессор М.Отгонбаяр (МУИС) Доктор (Ph.D), профессор Б.Дагзмаа (МУИС)
9:30	Академик орчин дахь их сургуулийн ёс зүйн асуудал: Олон улсын баримт бичгүүдэд хийсэн анализ. Доктор (Ph.D), дэд профессор Ц.Батцэрэн (ШУТИС) Магистр Э.Энхцолмон (ШУТИС)
10:15	Их, дээд сургуулийн ёс зүйн дүрмэнд хийсэн системийн шинжилгээний үр дүн Доктор (Ph.D) Г.Уянга (ХААИС) Магистр Б.Нарантунгалаг (“Ач” АУИС) Магистр Л.Долгор (Залуу судлаач сан)
10:30	Хувиран өөрчлөгдөж буй боловсролын хэрэгцээ ба СИИ сургалт “Нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцахуй” ТББ-ын гүйцэтгэх захирал А.Ариунзаяа
10:45	Нэгдүгээр хэлэлцүүлэг
11:15	Цайны завсарлага ҮДЭЭС ӨМНӨХ ХУРАЛДААН - ХОЁР Хуралдааны дарга: Доктор (Ph.D), дэд профессор Ц.Батцэрэн
11:30	Монголын боловсролын салбар дахь ёс зүйн асуудлууд Доктор (Ph.D), профессор Р.Дарьхүү (МУИС)
11:45	Их сургууль ёс зүйн боловсролын төв болох нь Доктор (Ph.D), профессор И.Лхам (ХААИС) Магистр Б.Отгонбаяр (ХААИС)
12:00	Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нар ба ирээдүйн чиг хандлага Доктор (Ph.D), дэд профессор Д.Оюунгэрэл (МУИС) Доктор (Ph.D), дэд профессор Г.Эрдэнэбаяр (МУИС)
12:15	Эрүүдэн шүүх ба ёс зүйн асуудал Доктор (Ph.D) Б.Мөнхжавхлан (МУИС) Доктор (Ph.D), профессор Б.Дагзмаа (МУИС)
12:30	Хоёрдугаар хэлэлцүүлэг
13:00	Үдийн хоол ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН Хуралдааны дарга: Доктор (Ph.D), профессор М.Отгонбаяр
14:00	N тооны жендер ба жендерийн зах зээл Магистр Э.Баасандорж (МУИС) Ц.Энх-Од
14:15	Спорт дахь хүйсийн ялгавар болон жендерийн асуудлыг ёс суртахууны философийн үүднээс хөндсөн тойм Доктор (Ph.D), дэд профессор Б.Буяндэлгэр (АШУУИС)
14:30	Шилжилтийн нийгэм дэх Z үеийнхний ёс зүйн зарим асуудал Доктор (Ph.D) Б.Цэрэнханд (“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль)
14:45	Хиймэл оюун ухаан (AI), машин сургалтанд суурилсан эрүүл мэндийн технологийн ёс зүйн зарим асуудал Магистр Т.Амгалан, Магистр Б.Одгэрэл, Магистр Б.Туул, Магистр С.Долгорсүрэн, Магистр Ц.Дашдулам (АШУУИС-ийн Сувилахуйн сургууль)
15:00	Орчин үеийн залуучуудын үнэт зүйлсийн чиг хандлага Докторант Ж.Каламхас (ШУТИС-ДаТС) Магистр Д.Дунгаамаа (ШУТИС-ДаТС)
15:15	Гуравдугаар хэлэлцүүлэг
15:45	ХААЛТ (дурсгалын зураг)

Мөн түүнчлэн тус төслийн удирдагч болон гүйцэтгэгч нар дараах хурлуудыг зохион байгуулахад оролцож, ёс зүйн эрдэм шинжилгээний ажлуудаасаа хэлэлцүүлж, үр дүнг хэвлүүлсэн болно. Тухайлбал,

Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан Философи, шашин судлалын тэнхимээс зохион байгуулсан “Гэр бүлийн ёс зүйн асуудал” (2020), “Ёс зүй цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” (2021), “Гоо зүйн боловсрол ба орчин үе” (2021) хурлыг тайланд дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Улаанбаатар хотноо 27 орны 500 гаруй эрдэмтэн судлаач оролцож, монголын түүх, антропологи, археологи, хэл бичиг, урлаг, утга зохиол, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, гадаад харилцаа, соёл уламжлалын чиглэлээр судалгаа шинжилгээнийхээ үр дүнг хэлэлцүүлсэн Олон улсын монголч эрдэмтний XII их хурлыг зохион байгуулахад төслийн удирдагч Д.Оюунгэрэл оролцохын сацуу “Төрийн хүний ёс суртахууны тухай зарим сурвалжаас тодруулахуй” илтгэлийг хэлэлцүүлж, үр дүнг нийтлүүлэхээр зохион байгуулагчдад хүлээлгэн өгсөн болно.

Зураг 5. Олон улсын монголч судлаач эрдэмтний XII их хурлын анонс (2023).



VIII.4. Эрдэм шинжилгээний илтгэлүүд

Дотоодын эрдэм шинжилгээний хуралд:

Баярчимэг Ч. “Ёс зүй цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” (2021) хуралд “Цар тахлын үеийн багшийн үйл ажиллагаа. Гадаад дотоодын хэвлэлийн мэдээнд тулгуурлав” сэдэвт илтгэл

Зураг 6. “Ёс зүй: Цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” хурлын эмхэтгэлийн нүүр



Зураг 7. “Цар тахлын үеийн багшийн үйл ажиллагаа” илтгэлийн нүүр

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

/Гадаад дотоодын хэвлэлийн мэдээнд тулгуурлав/

Ч.Баярчимэг доктор (Ph.D), дэд профессор
ХААИС-ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхим

Түлхүүр үг: *хэвлэлийн тойм, үндсэн чиглэл, төстэй байдал, вакцин, ажлын ачаалал, нэр төр*

Хураангуй: *Шинэ өвчинтэй нүүр тулж, хөл хорио тогтоосон цаг хугацааны үеэр багш нарын ажлын ачаалал урьд жилүүдээсээ нэмэгдсэн. Орон орны багш нар цахим орчинд заах арга болон сурагчидтайгаа харьцах харилцааны арга барилаа шинэчлэхэд хүрсэн нөхцөл байдалд сонин, цахим хуудас, олон нийтийн сүлжээн дэх боловсрол, багшийн талаар өгүүлсэн мэдээлэл, нийтлэл, ярилцлагуудыг түүвэрлэн авч агуулгыг шинжлэн үзлээ.*

Оршил

2020-2022 оны хичээлийн жилүүдэд цар тахлаас шалтгаалан дэлхий нийтээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн болон тусгай хэрэгцээт боловсрол, элсэлтийн ерөнхий шалгалтад өөрчлөлт орсон. Энэхүү нөхцөл байдалд хичээл, сургалт, багшийн ачаалал, дархлаажуулалтын аян, вакциныг дэлхий даяар хэрхэн хүлээн авч, хэвлэл мэдээлэлд хэрхэн тусгагдсан талаарх мэдээллүүдийг цуглууллаа.

Өнөөдөр 100 гаруй сэтгүүл, 100 гаруй сонин гарч байна. Сайтуудыг хасаад 450 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монголд бий. Сайтын тоо 200 хол давсан. Үүнээс 50 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг¹⁸.

¹⁸ М.Зулькафиль: Монголын хэвлэл мэдээллийн салбарт тулгарч буй гол асуудал бол эзэмшил. <https://ikon.mn/n/1a3s>. 2018 ОНЫ 5 САРЫН 2

Баярчимэг Ч. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” (2022) хуралд “Цахим эрин дэх багшийн дүр төрх” сэдэвт илтгэл.

Зураг 8. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” хурлын эмхэтгэлийн хавтас



ЦАХИМ ЭРИН ДЭХ БАГШИЙН ДҮР ТӨРХ

Цахим эрин дэх багшийн дүр төрх
Ч.Баярчимэг доктор (Ph.D) дэд профессор
ХААИС-ийн ХҮТ
chbayarchimeg@muls.edu.mn

Хураангуй: Шинэ цаг үеийн боловсролын шаардлага хангах чадварлаг багш бэлтгэх, бэлтгэсэн багшаа үргэлжлүүлэн хөгжүүлэх нь үндэсний хэмжээний тулгамдсан асуудал болж байна. Багш бэлтгэх, хөгжүүлэх, боловсролын чанарын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхэд олон улсын туршлага, орчин үеийн судалгаа, шинжилгээний үр дүнгүүдээс судлах шаардлагатай юм. Бүх шатны сургалтын багш нарт учирч буй асуудал, түүнийг даван туулах итгэл үнэмшил, удирдлага багш нарын хоорондын ойлголцол ямар байгааг судлах шаардлагатай байна. Цахим ертөнцөөс багш нарын доголдолтой тал голчлон харагддаг тул ирээдүйн багш нарт сөргөөр нөлөөлж байна.


Түлхүүр үг: Судалгааны дүн, багшийн нэр хүнд, багшийн хариуцлага, нийгмийн сүлжээ, ёс зүйн зөрчил, багшийн манлайлал

2020 оны 01 сараас 04 сарыг хүртэл, 2022 оны 02 сараас 2022 оны 04 сар хүртэл гүйцэтгэсэн “Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал” социологийн судалгааны дүнг энэхүү өгүүлэлд ашиглалаа. Судалгааны өгөгдөл цуглуулах ажилдаа нийт 1480 багш, сургуулийн удирдах ажилтан нараас судалгааг авч боловсруулалт хийх боломжтой өгөгдлүүдийг ашиглан судалгаанд оролцогчдын статистик мэдээллийг SPSS 22.0, Excel програмуудыг ашиглан боловсруулалт хийж, үр дүнг нэгтгэсэн. Өгөгдлийг боловсруулахдаа тайлбарлах дүгнэх аргыг ашигласан.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежийн нийт үндсэн багшийн тоо 52160 бөгөөд үүний 42256 нь эмэгтэй багш байдаг аж. Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн нийт 35110 багш нарыг хүйсний харьцаагаар авч үзэхэд эрэгтэй багш 6488, эмэгтэй багш 28642

Золзаяа М. Хиймэл оюун ухааны ёс зүй: сорилт ба хариуцлага. -“Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: философи асуудлууд”. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. УБ.,2020.

Зураг 10. “Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: философи асуудлууд”. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэлийн хавтас



Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: Философи асуудлууд

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЁС ЗҮЙ: СОРИЛТ БА ХАРИУЦЛАГА

М.Золзаяа

Доктор (Ph.D)

ШУА-ийн Философийн хүрээлэн

Хураангуй: Хиймэл оюун ухаан ба роботын хүн ба нийгэмд үзүүлэх сорилт, түүний ёс зүй асуудал нь хэрэглээний ёс зүйн шинэ чиглэл болон хөгжиж байна. Хиймэл оюун ухааны давуу тал, хор уршиг, аюулын талаар өгүүлэх үндэслэлүүд нь ёс зүйн агуулгатай байдаг. Харин манай улсад энэ талаар судалгаа тун хомс. Иймд бусад орны судлаачдын туршилага, судалгааны үр дүн, зөвлөмжийг тоймлон сургалт, сурталчилгаа, бодлого боловсруулахад ашиглаж байх нь зүйтэй юм. Энд хиймэл оюун ухааны ёс зүйн судалгааны хандлага, тулгарч буй сорилт, хариуцлагын талаар зарим жишээ, судлаачдын байр суурийг авч үзлээ.


Түлхүүр үг: хиймэл оюун ухаан, робот, ёс зүйн диллем

Нэг. Хиймэл оюун ухааны ёс зүй, түүний судалгаа: Хүн сэтгэж, машин тооцоолдог учраас хиймэл оюун ухаанд ёс зүй гэж байх уу?. 1950-аад оноос хөгжиж эхэлсэн хиймэл оюун ухаан эдүгээ бидний сонголт, шийдвэр, хүрээлэн буй орчин, нийгэм, соёлд нөлөөлж байна. Хиймэл оюун ухаан нь технологийн салбарынхан шийдвэрлэж чадахгүй олон асуудлыг үүсгэж, хууль, ёс суртахууны хэм хэмжээ тогтоох чухал болохыг харуулж байна. Хиймэл оюун ухааны ёс зүй (Artificial Intelligence ethics)-н хүрээнд дараах хэдэн асуудал төвлөрч байна. Үүнд: 1. Хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд баримтлах ёс суртахууны хэм хэмжээ, үнэт зүйл, зарчим. 2. Түүнийг амьдрал, үйл ажиллагаанд нэвтрүүлж, ашиглахад баримтлах ёс суртахууны хэм хэмжээ. 3. Дижитал технологийн системд бид юу хийх вэ?, системүүд өөрсдөө юу хийх вэ?, ямар эрсдэл учирч болох вэ?, бид хэрхэн хянах вэ? зэрэг асуултад хариулах. 4. Хариуцлага. Хар хайрцагны үйл ажиллагааг ойлгодоггүй хэрэглэгчид ямар хариуцлага хүлээх вэ? Инженерүүд машин зохион бүтээсний төлөө хариуцлага хүлээх үү? 5. Хиймэл оюун ухааныг ил тод, шударга, хариуцлагатай, үнэнч гэсэн ёс суртахууны хамгийн чухал хэм хэмжээтэй болгохын тулд яах вэ?, зэрэг нийтлэг асуудал байна.

2016 оны Дэлхийн эдийн засгийн форум дээр хиймэл оюун ухааны ёс зүйн тулгамдсан асуудлыг хэлэлцжээ. Үүнд, 1. Ажилгүйдэл. Робот ажиллах хүчийг орлохоор, олон ажлын байр, мэргэжил үгүй болох нь ямар эрсдэлтэй вэ? 2. Тэгш бус байдал. Машинаар бүтсэн баялгийг бид хэрхэн хуваарилах вэ?, илг

Золзаяа М. Нийгмийн тэгш бус байдлыг дискурсив ёс зүйн үүднээс шинжлэх нь. –Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. УБ.,2021. 68-73 дахь тал.

Зураг 12. Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэлийн нүүр.



НИЙГМИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫГ ДИСКУРСИВ ЁС ЗҮЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

М.Золзаяа
Доктор (Ph.D)
ШУА-ийн Философийн хүрээлэн

Хураангуй: XVIII зууны үеэс тэгш байдлын тухай үзэл, ойлголт өргөн хэлэлцэгдэх болжээ. Нийгмийн тэгш бус байдлын онол, арга зүйг XIX-XX зуунд Карл Маркс, Макс Вебер, Эмиль Дюркгейм нар социологийн шинжлэх ухааны үүднээс боловсруулсан. Тэгш бус байдал нь аль ч нийгмийн үед оршин байдаг үзэгдэл бөгөөд тэгш бус байдлыг бууруулах үзэл санаа нь ардын аман зохиолоос эхлээд онолын сэтгэлгээний хүрээнд боловсрон Олон Улсын хөгжлийн хөтөлбөрүүд, тунхгийн үндсэн зорилт болж улам нарийвчлагдсаар байна. Тэгш байдлын ёс суртахууны философи үндэслэл нь шударга ёсны тухай үзэлд холбогдоно, энэ утгаар дискурсив хандлагаар авч үзэх боломжтой.

Эдүгээ нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад эдийн засгийн, улс төрийн, үзэл суртлын, соёлын нөлөөллийн гэх мэт аргыг хэрэглэж байна. 2015 оны 9-р сард НҮБ-ын гишүүн 193 орны төрийн тэргүүнүүд “Тогтвортой хөгжлийн зорилгууд” хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн тэгш бус байдлыг бууруулах 10-р зорилгын хүрээнд олон талт арга хэмжээг хэрэгжүүлж буй. Тухайлбал, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас “Бүх нийтээр зохистой хөдөлмөр эрхэлснээр тэгш бус байдлыг бууруулж, эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлнэ. Шударга хөдөлмөрөөр орлого олох, ажлын байрны аюулгүй байдал, хувь хүн болон гэр бүлийн нийгмийн хамгааллыг онцолдгоороо зохистой хөдөлмөр нь орлого, хөрөнгө чинээ, эдийн засгийн нөлөөллийн тэгш бус байдлыг бууруулахад шууд нөлөөлөх арга хэрэгсэл юм”¹ гэж үзэж байна.

Нийгмийн боломжоос хүртэх харилцан адилгүй нөхцөл байдал нь тэгш бус байдлыг бий болгож буй. Тогтвортой хөгжлийн зорилго дахь тэгш бус байдлыг бууруулах зорилтод 2030 онд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих хэмээн заасан. Иймд илтгэлдээ нийгмийн тэгш бус байдлын шалтгаан, үр дагавар болон түүнийг бууруулах зорилтыг хангахад дискурсив ёс зүйн шинжилгээ хийх нь зохих үр нөлөөтэй болов уу хэмээн энэ талаарх цөөн тооны судалгаанаас эш санаа авч үзлээ.

Дискурс, дискурсийн анализ

Зураг 13. “Нийгмийн тэгш бус байдлыг дискурсив ёс зүйн үүднээс
шинжлэх нь” илтгэлийн нүүр

Золзаяа М, Дарьхүү Р. Ёс зүйг сэтгэл судлал мэтээр ойлгохуйг залруулах нь. //Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага. ЭШХ-ын эмхэтгэл. УБ.,2022. 41-52 дахь тал.

*Зураг 14. Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага.
ЭШХ-ын эмхэтгэлийн хавтас.*



Зураг 15. “Ёс зүйг сэтгэл судлал мэтээр ойлгохуйг залруулах нь”
илтгэлийн нүүр.

Ёс зүйг сэтгэл судлал мэтээр ойлгохуйг залруулах нь

ЁС ЗҮЙГ СЭТГЭЛ СУДЛАЛ МЭТЭЭР ОЙЛГОХУЙГ ЗАЛРУУЛАХ НЬ

Р.Дарьхүү
Доктор (Ph.D), профессор
М.Золзаяа
Доктор (Ph.D)

Хураангуй: Манай нийгэмд ёс зүйг сэтгэл судлал мэтээр ойлгох эсвэл сэтгэл судлалын боловсролоор ёс суртахууны боловсрол, хүмүүжил олгоно зэргээр эндүүрч тайлбарлах явдал түгээмэл байна. Үүний шалтгааныг тодруулан, боловсролын тогтолцооны бүх шатанд энэ алдааг залруулах асуудлыг илтгэлдээ дэвшүүлэн тавьж байгаа болно. Гол шалтгаан нь мэргэжлийн байгууллага, судлаачдын судалгаа, санал, зөвлөмжийг харгалздаггүй байдалтай шууд холбоотой гэж үзэж байна.

Сэтгэл судлал, ёс зүй нь үүсэл хөгжил, судлах зүйл, үндсэн нэр томьёо, онолын чиг хандлагуудаар ялгаатай. Сэтгэл судлал нь сэтгэц, ухамсрын үүсэл, хөгжил ба илрэх зүй тогтлын тухай шинжлэх ухаан. Ёс зүй нь ёс суртахууныг судалдаг философийн салбар ухаан болно. ЮНЕСКО-ийн шинжлэх ухаан, технологийн салбарын ангиллаар сэтгэл судлал нь нийгмийн шинжлэх ухаан, ёс зүй нь хүмүүнлэгийн ухаанд багтана.¹

Түлхүүр үг: ёс зүйн боловсрол, сэтгэц, психологизм, тархи судлал

Ёс зүй нь философитой хамт үүсэн хөгжиж ирсэн, ёс суртахууныг судалдаг философи мэдлэгийн салбар юм. Ёс зүй бол философийн ухааны бүрэлдэхүүн болохыг философийн түүх гэрчилнэ.

Сэтгэл судлалын хөгжлийн эхний үе шат буюу НТӨ VI-XII зууны хоёрдугаар хагаст философи болон бусад шинжлэх ухаан, ялангуяа байгаль шинжлэлийн хүрээнд хөгжиж байсан. Сэтгэл судлалын асуудлыг эртнээс философийн хүрээнд судалж, тайлбарлаж ирсэн байдаг. Үүний нэг жишээнд Аристотелийн хүрээнд судалж, «Зан авир - Charaktere» хэмээх бүтээлийг дурдаж болно. Энэ шавь Феофрастын «Зан авир - Charaktere» хэмээх бүтээлийг дурдаж болно. Энэ бүтээл нь эртний этографийн (үгчилбэл: зан, зан үйлийн тэмдэглэл гэсэн утгатай) бүтээлд тооцогддог бөгөөд ёс зүйн болон сэтгэл судлалын аль алиных нь түүхэнд тэмдэглэгддэг. Зохиогч тухайн үеийн Афины нийгмийн амьдралаас сэдэвлэж, хүмүүний гучин төрлийн зан авирыг нэг схемээр илэрхийлсэн бөгөөд түүнийхээр зан авир нь дундаж замыг олох хүсэл эрмэлзэл биш, харин сэтгэлийн сайн, муу талын илрэл² ажээ.

XVIII зуун хүртэлх философийн судалгаанд ёс суртахуун, сэтгэлийн ялгааг онцгойлон анхаараагүй байна. Тухайлбал, ёс суртахууны сэдлийн мөн чанарыг

¹ Фраскатын гарын авлага. Судалгаа, туршилт, хөгжлийн асуулгад баримтлах жишиг стандарт. OECD, France, 2002. 71-72 дахь тал.

² Этика. Энциклопедический словарь. М., 2001. С. 524-525.

Оюунгэрэл Д. “Ёс зүй цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” (2021) хуралд “Утилитар онолын үүднээс хэрэглээний ёс зүйн зарим асуудлыг тайлбарлах нь” сэдэвт илтгэл,

Зураг 16. “Ёс зүй: Цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа”

эмхэтгэлийн нүүр.



Зураг 17. “Утилитарист онолын үүднээс хэрэглээний ёс зүйн зарим асуудлыг тайлбарлах нь” илтгээлийн нүүр.

**УТИЛИТАРИСТ ОНОЛЫН ҮҮДНЭЭС
ХЭРЭГЛЭЭНИЙ ЁС ЗҮЙН
ЗАРИМ АСУУДЛЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ**


*Г.Эрдэнэбаяр, доктор /Ph.D/, дэд профессор
Д.Оюунгэрэл, доктор /Ph.D/, дэд профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

Түлхүүр үг: үр ашиг, цар тахал, нийгмийн сайн сайхан, эвтанази, амьтны эрх.

***Товч утга:** Хүн төрөлхтөнд нарийн төвөгтэй асуудал нэмэгдэхийн хэрээр хүмүүсийн харилцан хамаарал, эв нэгдэл, хариуцлага, үнэнч шударга байдал, итгэлцэл, хамтран ажиллах чадвар, харилцан туслалцаа, коммунитаризм зэрэг ёс суртахууны үнэт зүйлсийн үүрэг, ач холбогдол улам бүр нэмэгдэж байна. Орчин үеийн нийгмийн үйл ажиллагааны хамгийн чухал хэрэгцээ болж байгаа зүйл бол ёс суртахууны үнэт зүйлс (утга учир, бусдыг хүлээн зөвшөөрөх, ялгаатай байдлыг ойлгох, хүндлэл, бүтээлч байдал, өөрийн ухамсар, нийгмийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаа гэх мэт) юм. XXI зуунд даяаршлын үйл явц, харилцан уялдаа холбоотой байдал улам бүр нэмэгдэхийн хэрээр шинэ сорилт, эрсдэл бий болж байгаагийн хэрээр ёс суртахууны мэдлэг боловсролын хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна. Үүний тулд хувь хүн өөрийгөө хөгжүүлэхэд ёс зүйн мэдлэг хийгээд практик асуудалд анхаарлаа хандуулж, тэдэнд ул суурьтай хандах нь суурь үндэс болж байна. Өнөөдөр бид хэрхэн олон хүнийг өвчин зовлонгоос салгах вэ, хэрхэн нийтээрээ аз жаргалтай амьдрах вэ хэмээн ухаан бодлоо уралдуулж байна. Мөн түүнчлэн COVID-19 цар тахлын нөхцөл байдалд хүний эрхийн талаар нухацтай хэлэлцүүлэх олон асуудлаас дутахгүй бас нэгэн чухал асуудал бол амьтны эрхийн тухай, амьтныг хамгаалах ёс зүйн тухай юм. Бүрэн биш ч зарим хариултыг утилитаризмд хэрхэн авч үзсэнийг тодруулъя.*

Оюунгэрэл Д. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” (2022) хуралд “Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага” сэдэвт илтгэл,

Зураг 18. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” хурлын эмхэтгэлийн хавтас



Зураг 19. “Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага” илтгэлийн нүүр

Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл

**САЙН БАГШИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ:
ӨНӨӨГИЙН МОНГОЛЫН БАГШ НАРЫН ЁС СУРТАХУУНЫ
БАЙДАЛ БА ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА**

*Г.Эрдэнэбаяр доктор /Ph.D/, дэд профессор
Д.Оюунгэрэл доктор /Ph.D/, дэд профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

Түлхүүр үг: ёс суртахуун, харилцааны ёс зүй, соёл, хэм хэмжээ,

Товч утга: Аль ч үеийн түүхэнд хамгийн нэр хүндтэй мэргэжил бол багшийн мэргэжил байжээ. Багшийн хөдөлмөр бол олон талын мэдлэг, хүнтэй харилцах урлаг, суралцагчийн сэтгэхүйн онцлогийг судалж, ойлгож харилцаж чаддаг байхыг шаарддаг чухал мэргэжлийн нэг юм. Багш хүн суралцагчийг зөв жолоодож, ёс суртахууны хувьд төлөвшүүлж, амьдралын чигийг олоход тусалдаг хүн учраас түүхийн аль ч цагт хүндтэй мэргэжил юм. Ер нь багшийн мэргэжлийг төрмөл зан чанар дээр суурилах мэргэжил хэмээн үзэх нь бий. Мэдлэг, ур чадвараас гадна хүн чанар, хичээл зүтгэл, хүнлэг сэтгэл илүү шаарддаг учраас тэр.

Бид “Мэргэжлийн ёс зүйн асуудал” суурь судалгааны төслийн хүрээнд “Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын үр дүнд суурилан энэхүү илтгэлийг танилцуулж байна. Тус судалгаа нь:

1. Багшийн харилцааны ёс зүй, соёлын асуудал
2. Багшийн нийгмийн дүр төрх ба цахим орчин
3. Багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг, хариуцлагын тухай гэсэн гурван бүлэг бүхий 56 асуултаас бүрдсэн томоохон хэмжээний судалгаа болсон юм. Энэ удаагийн илтгэлд зөвхөн нэгдүгээр бүлгийг онцлон сайн багшийн тухай ойлголтыг тодруулан өнөөгийн байдал хийгээд ирээдүйн чиг хандлагыг тодруулан авч үзэх юм.

Үндсэн хэсэг:

Хүн бол тухайн улсын чухал баялаг мөн. Хүнийг хөгжүүлэх, төлөвшүүлэх боловсролын үндсэн зорилго байдаг. Иймд багш нь мэдлэг чадвартай байхаас гадна мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ,

Оюунгэрэл Д. “Бодь мөрийн зэргийн сургаал – орчин үед” хуралд “Бодь мөрийн зэрэг зохиол багшийн ёс зүйн тухай” сэдэвт илтгэл. (2023)

Зураг 20. Бодь мөрийн зэрэг орчин үед хурлын хөтөлбөр

Үдийн өмнөх хуралдаан БОДЬ МӨРИЙН ЗЭРГИЙН СУДЛАЛ ОЛОН УЛСАД

Хуралдааны дарга: М.Золзаяа (ШУА-ийн Философийн хүрээлэн, доктор)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнх-Отгон (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)

09:50-10:10 **М.Гантуяа** (ШУА-ийн Философийн хүрээлэн, доктор (Sc.D), профессор)

Б.Мөнхцацралт (ШУА-ийн Философийн хүрээлэн)

ОХУ дахь Бодь мөрийн зэргийн орчуулгууд

10:10-10:30 **Бадма Меняев** (ОХУ, Халимагийн Их Сургууль, доктор)

Тод үсгийн Бодь мөрийн зэргийн орчуулга, тайлбарууд

10:30-10:50 **Д.Наранцэцэг** (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор)

Сэргэлэн (БНХАУ, Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Академи)

БНХАУ дахь Бодь мөрийн зэргийн судалгаа, чиг хандлага

10:50-11:10 **М.Батаа** (ШУА-ийн Философийн хүрээлэн, доктор)

Д.Дэмбэрэл (ШУА-ийн Философийн хүрээлэн, доктор)

БНСУ дахь Бодь мөрийн зэргийн судалгаа, орчуулгын асуудалд

11:10-11:30 **Ц.Алтанхүү** (Зүүн хүрээ Дашчойлин хийд)

Бодь мөрийн зэргийн судлал өрнө дахинд

11:30-11:50 **Дарханхүү** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)

Бодь мөрийн зэргийн монгол тайлбар, орчуулга, бар хэвлэл, судалгааны тойм

11:50-12:10 **Хэлэлцүүлэг**

12:10-13:00 **Үдийн зоог** (Намасте буфет)

Үдийн хойнох хуралдаан **БОДЬ МӨРИЙН ЗЭРГИЙН СУРГААЛ ОРЧИН ҮЕД**

Хуралдааны дарга: О.Шинэбаяр (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхцацралт (ШУА-ийн Философийн хүрээлэн)

13:00-13:20 **Н.Бэгз** (БШУЯ-ны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, академич)

Бодь мөрийн зэргийн багшийг шүтэх ёсны уламжлал өнөө үед

13:20-13:50 **Д.Бүрнээ** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, доктор, профессор)

Бодь мөрийн зэргийн дохионы тайлбар (дадол)-ын тухай

13:50-14:10 **Г.Мягмарсүрэн** (Дашчойлин хийд, Бурхны шашин соёл судлалын хүрээлэн, доктор)

Бодь мөрийн зэргийн товчлол зохиолын жишээ

14:10-14:30 **М.Саруул-Эрдэнэ** (АНУ, Конгрессын номын сан, доктор)

Ажиа гэгээний намтар дахь богд Зонхавын талаарх өгүүлэмж

14:30-14:50 **Д.Даваасүрэн** (СУИС-ийн Театрын урлагийн сургууль, доктор, профессор)

Бодь мөрийн зэрэг дэх "Магад гарах санаа" хэмээх нэгэн зүйл сэтгэлийн эрдэм

14:50-15:10 **Д.Оюунгэрэл** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, доктор)

Бодь мөрийн зэрэг зохиол дахь багшийн ёс зүйн тухай

15:10-15:30 **Ч.Батнайрамдал** (АШУҮИС-ийн Уламжлалт анагаах ухааны сургууль, доктор)

Д.Санжайжамц (АШУҮИС-ийн Уламжлалт анагаах ухааны сургууль)

Бодь мөрийн зэрэг бүтээл дэх эрүүл аж төрөх ёсны ойлголт

15:30-16:00 **Хэлэлцүүлэг**

16:00-16:30 **Хурлын хаалт: Б.Пүрэвсүрэн** (ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор)

Б. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд:

1. Баярчимэг Ч, Золзаяа М, Оюунгэрэл Д. Хэл, соёл, боловсролын тулгамдсан асуудал. (2021) хуралд “Монголын хэвлэл мэдээлэлд багш мэргэжлийн ёс зүйн талаар туссан нь” сэдэвт илтгэл.

Зураг 21. Хэл, соёл, боловсролын тулгамдсан асуудал ОУЭШ хурлын анонс



Зураг 22. “Монголын хэвлэл мэдээлэлд багш мэргэжлийн ёс зүйн талаар туссан нь” сэдэвт илтгэлийн нүүр.

БАГШ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТАЛААР ТУССАН НЬ

М.Золзаяа -ШУА-ийн ФХ, доктор (Ph.D)

Д.Оюунгэрэл -МУИС-ийн ШУС, доктор (Ph.D), дэд проф.

Ч.Баярчимэг -ХААИС, доктор (Ph.D)

Key words: *prestige, status, duty, responsible, culture of communication*

Багш мэргэжлийн ёс зүйн асуудал хэвлэл мэдээллийнхний анхаарлын төвд байдаг. Өдөр тутмын сонин, радио, телевиз, вэб сайтууд дахь боловсрол, багшийн талаарх мэдээлэл, нийтлэл, ярилцлагуудаас багш мэргэжлийн ёс зүйд холбогдох агуулгыг шинжлэн үзлээ. Сонин, вэб сайтыг сонгохдоо Монголын хэвлэлийн хүрээлэнгийн хэрэглэгчдийн үнэлгээний судалгааны дүн болон эхийн объектив, үнэн магадтай шинжийг шалгуур болголоо. Илтгэлд багшийн харилцааны соёл, үүрэг, мэргэжлийн нэр хүндийг утгын нэгжээр тодорхойлон шинжлэхийг оролдов.

Багшийн харилцааны соёл

Багшийн харилцааны чухал хүрээнд бол оюутан суралцагч, тэдний гэр бүл, мөн хамт олон зэрэг багтдаг. XXI зуунд харилцааны ур чадварыг чухалчлах болсон бөгөөд “Өөрийгөө чухалчлахдаа гол бус, бусдыг мэдрэх” чухал хэмээн үзэх болжээ. Тиймээс харилцааны соёлтой, харилцах ур дүйтэй, хүний оронд өөрийгөө тавьж боддог, өөрийгөө бүх юмны төв гэж үзэлгүй хүнлэг даруу, зөв ойлгуулж, бусдыг зөвөөр ойлгодог байхыг чухалчлах болов. Учир нь хүмүүсийн харилцах тодорхой хэм хэмжээн дээр харилцааны соёл бий болдог. Сайн багш гэж байдгийн нэгэн адил саар багш гэж байдаг уу? Яагаад зарим багш хүндэтгэл хүлээж, зарим нь тийм байж чаддаггүй вэ? Энэ нь тухайн багш мэргэжлийн чадвартай хэдий ч харилцааны

Оюунгэрэл Д. Олон улсын монгол судлаач эрдэмтний XII их хуралд (2023) “To determine the ethical issues of civil servants based on several resources”.
Улаанбаатар. 2023 оны 08-р сарын 9-14-ны өдөр.

Зураг 23. Олон улсын монгол судлаач эрдэмтний XII их хурлын хөтөлбөр

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ҮХНААГИЙН
ХҮРЭЛСҮХИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ
“МОНГОЛЫН ЭНХ ТАЙВАН БА ТҮҮХЭН ТҮРШЛАГА” СЭДЭВТ
ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ XII ИХ ХУРАЛ
(МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, 2023.VIII.09-14)**

**THE 12th INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS “PAX
MONGOLICA AND HISTORICAL EXPERIENCE”
UNDER THE AUSPICES OF THE PRESIDENT OF MONGOLIA
KHURELSUKH UKHNAА
(09-14 AUGUST 2023, ULAANBAATAR, MONGOLIA)**

ХӨТӨЛБӨР PROGRAM

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



ОЛОН УЛСЫН МОНГОЛ
СУДЛАЛЫН ХОЛБОО

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



СОЁЛЫН ЯАМ



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УЛААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



ЧИНГИС ХААН
УЛААНБААТАР



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ
УЛААНЫ ИХ СУГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УЛААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УЛААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УЛААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСЛАТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УЛААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

2023 оны 8 дугаар сарын 11. Баасан гараг / Friday, August 11, 2023

Үдээс хойших хуралдаан: 14:00-18:00 / Afternoon session: 14:00-18:00

Хуралдааны дарга: Г.Чулуунбаатар (Монгол Улс)
Moderator of the session: G.Chuluunbaatar (Mongolia)
Нарийн бичгийн дарга: Д.Гоо (БНХАУ)
Secretary of the session: Gao, Wa (China)

- 14:00-14:20 **Ш.Ганхуяг** (Монгол Улс), **Ш.Ариунаа** (Монгол Улс). *Соёл хоорондын харилцааны онол, арга зүй*
- 14:20-14:40 **Ванг Хаймей** / Naimei (БНХАУ). *Нүүдэл соёл хийгээд зохицолдохуй гоо зүйн учир*
- 14:40-15:00 **Д.Оюунгэрэл** (Монгол Улс). *Төрийн хүний ёс суртахууны тухай зарим сурвалжаас тодруулахуй*
- 15:00-15:20 **Б.Мөнгөнчимэг** (ХБНГУ). *Монголын бурхны шашин дахь Жамсран сахиусын үүрэг, XXI зууны ижилсэл*
- 15:20-15:40 **Хэлэлцүүлэг / Discussion**
- 15:40-16:00 **Цайны завсарлага / Coffee Break**
- 16:00-16:20 **Ghilyana Dordzhieva** (USA). *Long-songs of the Kalmyks and Oirats: the peculiarity of the musical style*
- 16:20-16:40 **Lidiia Dashieva** (Russia). *Long songs of the Mongolians*
- 16:40-17:00 **Дмитрий Иванов** (Россия). *Монгольские этнографические коллекции Д.Д.Букинича в собрании МАЭ РАН*
- 17:00-17:20 **Б.Баатархүү** (Монгол Улс). *Монгол угсаатны хөгжлийн явц (Алтайн тувачуудын жишээгээр)*
- 17:20-17:40 **Жанна Юша** (Россия). *Тувинцы Монголии: специфика анклавной традиции*
- 17:40-18:00 **Хэлэлцүүлэг / Discussion**

Зурга 24. “To determine the ethical issues of civil servants based on several resources” илтгэлийн нүүр

TO DETERMINE THE ETHICAL ISSUES OF CIVIL SERVANTS BASED ON SEVERAL RESOURCES

*Oyungerel Dashdorj
Doctor (Ph.D), Associate professor
Department of Philosophy and Religious Studies
School of Arts and Sciences, Division of Humanities
National University of Mongolia
Mongolia.*

Keywords: moral norms, justice, duties, moral principles.

Abstract: We will consider moral values in various sources, both within the framework of the concepts of moral duty, justice, and responsibility, and the facts that related civil servants must study and follow. For example, the idea of the “Oyun tulkhuur”, which has become an indispensable imperative of Mongolian existence, defines the principles of human freedom and responsibility, desire, and restraint, justice and responsibility, and the ethical norms of making a difficult choice. This commentary text shows that moral duty is the basis of human existence and coexistence with other people. Recognizing and studying this, the traditional culture and thought of Mongolians about moral duties is the basis of many duties that we consciously fulfill from the perspective of our morality and humanity. In this context, this paper will discuss the importance of re-enforcing the traditional style of moral duty, as well as its characteristics, importance, and historical common values.

The traditional understanding of Mongolians about moral duty, responsibility, and justice has many lessons for our lives today. The moral values of Mongolians are inextricably linked with the unique characteristics of our customs and civilization. On one hand, the “Oyun tulkhuur” commentary text teaches about the moral relationship between master and subject, especially the fair procedure; on the other hand, it teaches about the moral development of the common people with social values and opinions of the time. Even during and after the imperial period, the most important characteristic of a state official and leader was not only knowledge but also ethical maturity and awareness of moral duties. Therefore, it is one of the features of the book that the king is specially taught about the moral duties and principles of the king, and many things can be applied to the activities of modern public service.

Based on commentary text, which is the main issue of Mongolian traditional ethics, it is considered to be one of the important conditions to preserve the national cultural identity, to continuously study the issue of moral philosophy in a broader context and in


VIII.5. Эрдэм шинжилгээний өгүүллүүд

Тус төслийн хүрээнд хэвлэгдсэн өгүүллүүд. Үүнд:

Оюунгэрэл Д. Боловсролын зорилгын тухай зарим философичийн үзэл санаа.

МУИС. Боловсрол судлал сэтгүүл. УБ.,2022

*Зураг 25. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. 2022 оны дугаарын хавтас.
өгүүллийн нүүр*



БОЛОВСРОЛЫН ЗОРИЛГЫН ТУХАЙ ЗАРИМ ФИЛОСОФИЧИЙН ҮЗЭЛ САНАА

Г.Эрдэнэбаяр, доктор, дэд профессор
(МУИС, ШУС, НУС, ФШСТ)
Д.Оюунгэрэл, доктор, дэд профессор
(МУИС, ШУС, НУС, ФШСТ)

Товч агуулга: 2002 онд баталсан Монгол Улсын Боловсролын тухай хуулинд боловсролын зорилгыг “иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахихаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”¹ хэмээн заасан байдаг. Эдүгээ манай улс боловсролын тухай хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилж байна. Тэрхүү хуулийн төсөлд боловсролын зорилгыг “төрт ёс, түүх, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай иргэнийг хөгжүүлэхэд оршино”² хэмээн удахгүй батлахаар мэргэжлийн байгуулага, эрдэмтэн, иргэдийн санал асуулгыг явуулж байна.

Боловсрол гэж юу болох, түүний мөн чанар, үүрэг, ач холбогдлын тухай асуудал боловсролын философийн түүхэнд чухлаар тооцогддог юм. Философийн түүхэнд янз бүрийн үзэл санаа дэвшигдэн, эрин цаг үеэ бүтээж байв. Чухам тэдгээр гайхалтай үзэл санаанд боловсрол, түүний зорилго, мөн чанарын тухай санаанууд дэвшигдэжээ. Энэхүү өгүүлэлд хүн төрөлхний оюун санааны түүхэнд чухал хувь нэмрээ оруулсан зарим сэтгэгчийн үзэл санааг авч үзэх болно.

Боловсролын зорилго нь хувь хүнийг бүх талаар хөгжүүлэхэд чиглэдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь бие бялдар, сэтгэл санаа, оюун ухааны төлөвшилийг хүнд олгох, улмаар ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэнэ гэсэн үг юм. Философийн сэтгэлгээний түүхэнд хүнийг хүмүүжүүлж, гэгээрүүлж ирсэн түүхээс харахад нийгмийн хөгжлийг дагаж боловсролын зорилго нь өөр өөрөөр тавигдаж байжээ.

Түлхүүр үг: хүний мөн чанар, эрхэм хүн, мунхаг харанхуй байдал, гэгээрэл.

Күнзийн философид: Күнзийн сургаал нь хятадын философийг бие даасан шинжийг олоход онцгой чухал үүрэг гүйцэтгэж, улмаар цаашдын хөгжилд чухал хувь нэмэр оруулсан, хүмүүнлэг үзлийг сурталчилсан байдаг. Тэрбээр хятадын философийн түүхэнд хамгийн нөлөө бүхий хүмүүнлэг үзэлтэн байсан гэгддэг. Хэдийгээр Күнзээс өмнөх үед хүмүүнлэг үзэл байсан гэх баримт байдаг ч гол нь өөрийн сургаалыг хятадын философийг өөрийн гэсэн өнгө төрхөө олоход хүчтэй хөдөлгөгч хүч болгож чадсанаараа онцлогтой билээ.

Хувь хүнийг бүх талаар хөгжүүлэх тухайд түүний философийн үзэл санаан

дотроос хамгийн чухал нь хүмүүнлэг боловсролын тухай, хүнлэг ёсны тухай байдаг. Өөрөөр хэлбэл, ёс суртахууны хувьд хүнийг төгөлдөржүүлэх явдал бол түүний хувьд гол зорилго гэж хэлж болно. Энэ утгаараа Күнзийн философи нь “хүн хүмүүн ёсоор байх байхгүйн тухай асуудлыг хөндөн захисан, хүн гээч амьтан бүхэнд зам мөрийг нь хэлэх гэсэн”³ ажээ. Хүн шиг хүн буюу эрхэм хүн байхын утга учрыг хүнлэг ёс буюу өршөөл хэмээх ойлголтоор Күнз олон талаас тайлбарлажээ. Ингэхдээ түүний үндсэн баримтлал бол “өршөөлт хүмүүн л өрөөл бусдыг хайрлаж чадмой” болно. Күнзийн үзлээр “хүнлэг, энэрэнгүй” байхын тулд


¹ <https://legalinfo.mn/mn/detail/9020>

² <https://lawforum.parliament.mn/draft/75/2022.03.01> байдлаар

³ Күнз. Лунь-Юй буюу бодрол агаад яриа. УБ., 2015. 11 дэх тал.

Оюунгэрэл Д. Багш мэргэжлийн ёс зүй: тулгамдаж байгаа асуудал ба шийдэх арга зам. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. УБ.,2023

Зураг 26. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. 2023 оны дугаарын хавтас. өгүүллийн нүүр



**БАГШ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ: ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ БА ШИЙДЭХ
АРГА ЗАМ**

Г.Эрдэнэбаяр, доктор, дэд профессор
(МУИС, ШУС, ХУС, ФШСТ)

Д.Оюунгэрэл, доктор, дэд профессор
(МУИС, ШУС, ХУС, ФШСТ)

Товч утга: Хүнийг хөгжүүлэх, төлөвшүүлэх боловсролын зорилгыг хэрэгжүүлэх хамгийн чухал субъект бол багш мэргэжилтэн байдаг. Багш мэргэжлийн ёс зүй нь нийт нийгмийн хөгжилд чухлаар нөлөөлөх нэгэн хүчин зүйл мөн. 2022 оныг БШУЯ-аас салбарын ёс зүйн жил болгон зарласан нь тохиолдлын хэрэг биш юм. Сүүлийн жилүүдэд багшийн ёс зүйн асуудал нийгэмд багагүй шуугиан дэгдээж, эцэг эх, багш сурагчдыг төдийгүй нийт нийгмийг бүхмидуулах явдал тохиолдох боллоо. Энэ нь манай улсын боловсролын шинэчлэлийн үйл явцад харуулж байна. “Мэргэжлийн ёс зүйн асуудал” суурь судалгааны төслийн хүрээнд “Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын үр дүнд суурилан энэхүү өгүүллийг бичив. Тус судалгаа нь: багшийн харилцааны ёс зүй, соёлын асуудал, багшийн нийгмийн дүр төрх ба цахим орчин, багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг, хариуцлагын тухай гэсэн гурван бүлэг бүхий 56 асуултаас бүрдсэн судалгаа юм. Энэ удаагийн өгүүлэлд багш мэргэжлийн ёс зүйд тулгамдаж буй асуудлыг харилцааны ёс зүйн талаас тодруулан авч үзэх юм.

Түлхүүр үг: багшийн ёс зүй, үүрэг хариуцлага, соёл, ёс зүйн дүрэм, харилцаа.

Багшийн ёс зүйн тухай ярихад харилцааны тухай ярихгүй өнгөрч болохгүй. Харилцааг олон янзаар тодорхойлж болно. Юуны өмнө харилцаа бол хүмүүс хооронд мэдээлэл солилцох үйл явц юм. Энэ явцад харилцаа нь нөлөөлөл болж байдаг. Түүнчлэн харилцаа бол хүний дотоод сэтгэлийн хэрэгцээ байдаг. Хүн бол бие биетэйгээ хамтарч ажиллах, бие биедээ татагдах, бие биеэсээ урам зориг авч, эерэг зөөлөн харьцааг мэдрэх хүсэл тэмүүлэлтэй байгалиасаа заяасан хамтач шинжтэй амьтан юм. Харилцааны явцад хүний хувийн болоод нийгмийн хэрэгцээ хангагдаж гоо зүйн, ёс суртахууны гэх мэт мэдрэмжүүд бий болж, улмаар эерэг, сөрөг төлөвлүүд бүрддэг. Харилцааны ёс зүй нь аливаа харилцаанд илэрч байдаг ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлдэг.

Багш мэргэжлийн хувьд хүнтэй харилцах харилцаа хамгийн чухал нь байдаг. Багш бол харилцааны ёс зүй, соёл, харилцах арга барил, эв дүйгээрээ бусдад ямагт үлгэр дуурайл болж байх үүрэгтэй. Иймээс харилцааны ёс зүй, соёлын хувьд багш хүн бусдаас илүү харилцах эв зүй, ур чадвартай байхыг шаардана. Үргэлж өөртөө дүгнэлт хийн, өөрийгөө хөгжүүлж байх нь мэргэжлийн шаардлага мөн. Энэ шаардлагыг биелүүлэх, ухамсарлах нь түүний ёс суртахууны үүргийн салшгүй хэсэг.

Орчин үеийн багшийн ёс зүйн хэм хэмжээнд дараах зүйлсийг багтаасан байдгийг япон, хятад, америк зэрэг орны багшийн ёс зүйн дүрмээс харж болохоор байна. Үүнд:

- Суралцагчийн аюулгүй байдлыг хангах,
- Хүүхдэд ээлтэй, халуун дулаан уур амьсгалтай орчин бүрдүүлж чаддаг байх,
- Хэт найзархаг биш, мэргэжлийн харилцаатай байх,
- Ялгаварлан гадуурхдаггүй байх,
- Бэлгийн чиг хандлагаа суралцагчдад илэрхийлдэггүй байх,
- Суралцагчдын хүчийг буруугаар ашигладаггүй байх,

Зураг 27. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. 2020 оны дугаарын хавтас, өгүүллийн нүүр



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

72+74.202
Б 553
2023896
МУИС - Эрдэм шинжилгээний фонд



2020-6093

МОНГОЛ
УЛСЫН
ИХ
СУРГУУЛЬ

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Энэхүү дугаарыг Боловсрол, сэтгэл судлалын
тэнхимээс эрхлэн гаргав.

ISSN-1818-8478

2020 Дугаар 20 (530)

ГАРЧИГ

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Х.Адъяацогт, Б.Уламбаяр

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР БА ОЮУТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ SERVQUAL АРГААР ТОДОРХОЙЛОХ НЬ (*Орхон аймгийн их, дээд сургуулиуд болон МСҮТ-ийн жишээн дээр*)..... 5

Х.Алтанхундага, Бал.Туяа

ЦЭЦЭРЛЭГИЙН АХЛАХ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ИЛРҮҮЛЭГ, ЭРТ ҮЕИЙН ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ТУРШСАН ҮР ДҮН 18

А.Алимаа

СУРАЛЦАГЧИЙН СОНСОХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ НЬ26

Х.Булган-Эрдэнэ

ТӨГСӨГЧДИЙН ДАХИН СУРАЛЦАХ ХЭРЭГЦЭЭГ СУДАЛСАН НЬ30

Б.Нацагдорж

БАГШИЙН АЖЛЫН БАЙРАНД МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН..... 35

Ц.Нямаа, Ж.Даваа

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ХӨТӨЛБӨР..... 42

Э.Октябрьжаргал

БАГШИЙН ХАНДЛАГА СУРГАЛТЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НЬ..... 47

Ч.Отгон, С.Нансалмаа

ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЭХЛЭЛ БИЕ ДААЛТ БОЛОХ НЬ..... 56

П.Түмэнгэрэл, Ц.Алтанчимэг

ОЮУТНУУДАД СТРЕСС ҮҮСГЭЖ БУЙ АКАДЕМИК ХҮЧИН ЗҮЙЛС 61

Г.Цэрэндоггор, Ц.Орхон

DEVELOPMENT AND ATTITUDE OF MODERN LEARNING ASSESSMENT 70

Ц.Энхнаран

ГАДААДАД СУРАЛЦАЖ БУЙ ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ СЭДЛИЙН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН..... 74

Г.Эрдэнэбаяр, Д.Оюунгэрэл

ПЛАТОНЫ АГУЙН ЁГТЛОЛ БА БОЛОВСРОЛ..... 84

Shuang Dalai, Л.Чулуунбаатар

ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖЛИЙН ОНОЛЫН АСУУДАЛ..... 88


Zhao Xiaohua

ОЮУТАНД ШААРДЛАГАТАЙ ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХЭЛБЭР 93

СЭТГЭЛ СУДЛАЛ

М.Дэлгэржав, Д.Мөнхдэлгэр,

СУРАГЧДЫН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ОЮУН УХААНЫ ТҮВШИН БОЛОН ГЭР БҮЛИЙН БУСАД ГИШҮҮДЭД ТАНИГДАХ ЧАДВАРЫН ХАМААРЛЫГ ТОДРУУЛАХ СУДАЛГАА..... 101



ISSN 2220-959X

PRS

Philosophy,
Religious
Studies

Official Journal of the National University of Mongolia

VOLUME 25 (580)



ЁС ЗҮЙН РЕЛЯТИВИЗМ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

*Г.Эрдэнэбаяр, доктор, дэд профессор
Д.Оюунгэрэл, доктор, дэд профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

Түлхүүр үг: Соёлын ялгаа, харьцангуй байдал, ёс суртахуун, ёс суртахууны хэм хэмжээ

Товч утга: Энэхүү өгүүлэлд янз бүрийн соёлууд ёс суртахууны өөр өөр кодтой тухай өгүүлнэ. XX зууны 40-50-иад оны үед европ болон америкт нийгэм соёлын онол сэтгэлгээнд нэгэн чухал байр суурь бүхий чиглэл орж ирсэн нь соёлын релятивизм байв. Энэ нь улс үндэстэн бүрийн соёлын онцлогийг харгалзан үзэх, зарим ард түмний соёлыг зэрлэг, бүдүүлэг мэтээр доромжилсон агуулгаар хандахгүй байхыг уриалж, евроцентризм нь хэтэрхий явцуурч, туйлишрч байгааг шүүмжилж гарч ирсэн. Энэ онолын төлөөлөгчид нь өрөөсгөл байдлаас зайлсхийх, соёл хоорондын ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах зорилгыг агуулсан ёс зүйн релятивист үзлийг сөргүүлэн тавьсан юм. Ёс зүйн релятивизмыг ойлгох, түүний агуулгыг хүлээн зөвшөөрөх өнцөг хаана байж болох вэ?

Энэ үзэл санааг ярихын өмнө зарим соёл дахь өвөрмөц зан үйлийн хоёр жишээг авч үзье.

Жишээ 1. Эртний Персийн хаан Дариус аялах дуртай нэгэн байсан бөгөөд түүний сонирхлыг татдаг зүйл бол янз бүрийн соёл дахь зан үйлүүд байжээ. Жишээлбэл, Энэтхэгийн нэгэн овгийнхон болох каллатичууд нас барсан эцгийнхээ цогцсыг иддэг бол эртний грекчүүдийн хувьд чандарлах нь оршуулгын ёслолд хамгийн тохиромжтой арга гэж үздэг байв. Соёл хоорондын ялгаатай байдлыг хэрхэн үнэлэх нь түүний хувьд сонирхолтой байжээ¹.

Грекчүүдийн хувьд нас барсан эцгийнхээ цогцсыг идэх нь байж боломгүй зүйл бол харин каллатичуудын хувьд нас барсан эцгийнхээ цогцсыг шатаах нь тэднийг гүн цочролд оруулах зүйл байв. Ингэхлээр янз бүрийн соёл дахь ёс суртахууны хэм хэмжээ өөр өөр байдаг байх нь. Нэг бүлгийн дотор зөв гэж үнэлэгдэж байгаа зүйл нь нөгөө бүлгийн хувьд буруу хэмээн үнэлэгдэж болох юм. Нас барсан хүний цогцсыг идэх үү эсвэл шатаах уу?

Хэрэв та грек эсвэл каллати хүн байсан бол хариулт мэдээж тодорхой.

Жишээ 2. 1996 онд Нью-Жерси дэх Ньюарк олон улсын нисэх онгоцны буудалд 17 настай Фаузия Кассинджа гэдэг охин орогнол хүссэн байна. Тэрээр өөрийн төрөлх Баруун Африкийн Того улсаас зугтаж ирсэнээ учирласан нь дараах шалтгаантай байв. Тус улсад охидын хэлүүг зүсэх мэс засал хийдэг байдал нэгэнт уламжлал болсон ажээ. Фаузия Кассинджа нь таван охинтой айлын отгон нь байв. Ачаа тээврийн ажил эрхэлдэг аав нь тус зан үйлийг эсэргүүцэж эхний дөрвөн охиноо зэрэмдэглүүлэхгүйгээр гэрлүүлж чадсан. Гэвч Фаузияг 16 настай байхад нь аав нь гэнэт нас баржээ. Ингэснээр тэр авга эгчийнхээ мэдэлд очиж, түүний зааснаар мэс ажилд орохоор болжээ. Фаузия айдаст автсан бөгөөд гэр бүлийн бусад гишүүд нь түүнийг оргон зугтаахад нь тусалсан байна. ... Барууны орнуудад үүнийг «эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх» гэж нэрлэдэг. ДЭМБ-ын мэдээлснээр “Африкийн 29 улс оронд уг зан үйлийг хийдэг бөгөөд ойролцоогоор 125

¹ James Rachels. *The Elements of Moral Philosophy*. 1998, p.15

III.6. Ном товхимол


VII.3. “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” бүтээл

Орчин үед дэлхий дахинд мэргэжлийн ёс зүйн асуудлаар сургалт, судалгааны ажил улам өргөн цар хүрээтэй болж байна. Учир нь мэргэжлийн ёс зүй бол мэргэжилтнүүдийн ёс суртахууныг төлөвшүүлэх, мэргэжлийн ёс суртахууны харилцааг сайжруулах, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг, түүнчлэн ЮНЕСКО-гийн зүгээс мэргэжлийн ёс зүйн боловсрол бол хүмүүсийг зөвхөн хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх гэхээс илүү амьдралын үнэт зүйл, үнэ цэнийг авчирдаг болохыг тус номын зохиогч анхаарч тус бүтээлээ бичжээ.

“Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” бүтээл нь Мэргэжлийн ёс зүйн судалгааны тойм, Мэргэжлийн ёс зүйн онолын үндэс, Их дээд сургуульд мэргэжлийн ёс зүйн мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлж буй туршлага, Мэргэжлийн ёс зүйн хичээлийн агуулга гэсэн дөрвөн бүлэгтэй.

Нийгэм хөгжихийн хэрээр мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн ёс зүйн шаардлага нэмэгддэг болохыг гадаадын болон дотоодын бодит кейс, жишээ баримтаар нотлон илэрхийлсэн бөгөөд өнөөгийн монголын нийгэмд өндөр мэдлэг бүхий иргэн шаардлагатай байгаагийн зэрэгцээ, үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс суртахуунтай мэргэжилтэн хэрэгтэй байгаад дүгнэлт хийж доктор Ч.Баярчимэг тус бүтээлээ бичсэн.

Их, дээд сургуульд бэлтгэж буй мэргэжилтэн нь нийгэм, хамт олны өмнө гүйцэтгэх үүрэг, хариуцлагаа ойлгосон, зөв төлөвшилтэй болоход ямар хүчин зүйл нөлөөлдөг, ямар арга замаар төлөвшүүлэх боломжтойг тогтоох нь нийгмийн шаардлага болон тавигдаж байна. Мэргэжлийн ёс зүй нь нийгмийн харилцааг боловсронгуй болгож, суралцагчдыг бие хүн болгон төлөвшүүлэхэд энэ бүтээл хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.



Зураг 29. “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага”

бүтээлийн хавтас

VII.4. “Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томьёоны товч тайлбар толь” бүтээл

Төслийн үр дүнгийн даалгаварт дурдсан мэргэжлийн ёс зүйн нэр томьёоны тайлбар толь хэвлүүлэх ажлыг суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэв. “Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томьёоны товч тайлбар толь”-ийг Ч.Баярчимэг, Д.Оюунгэрэл нар бичиж, М.Золзаяа хянан тохиолдуулан Тото пресс хэвлэлийн газраар хэвлүүлэв. Тус тольд ёс зүйн үндсэн мэдлэг, мэргэжлийн ёс зүйд түгээмэл хэрэглэгддэг болон түүнд холбогдох хэрэглээний ёс зүйн 180 орчим нэр томьёоны товч тайлбарыг боловсруулан бичив.

Нэр томьёо судлаачид “аливаа шинжлэх ухааны тулгуур буюу үндсэн ойлголт, ухагдахуун (нэгж мэдлэг)-ыг нэрлэсэн нэр томьёог түлхүүр нэр томьёо” гэж тодорхойлжээ. Тухайлбал, ёс зүйд сайн, муу, шударга ёс зэрэг үндсэн ойлголт нь түлхүүр нэр томьёо гэж болно. Ёс зүйн ухааны үндсэн ойлголтууд нь мэргэжлийн ёс зүйд ч хэрэглэгддэг тул зохиогчид эдгээрээс гадна ёс суртахууны эгэл хэм хэмжээ, эерэг, сөрөг үзэгдлийг илэрхийлсэн ойлголтуудыг ч тайлбарласан байна.

Сүүлийн үед мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагууд мэргэжлийн ёс зүйн дүрэм боловсруулж, ёс зүйн зөвлөлийг байгуулахад анхаарч идэвх санаачилгатай ажиллах болсон. Иймд ёс зүйн нэр томьёог зөв бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах хэрэгцээ шаардлага байгааг төслийн багийнхан ойлгож, энэхүү толь бичгийг хэрэглэгчдэд хүргэсэн. Манай төслийн баг тус суурь судалгааг гүйцэтгэх явцад толь бичиг, судалгааны бүтээл, сурах бичгүүд, эрх зүйн баримт зэрэг хэрэглэгдэхүүнд тулгуурлан мэргэжлийн ёс зүйд түгээмэл хэрэглэгддэг нэр томьёоны жагсаалт гаргаж тайлбарлан эмхэтгэв. Энэхүү тольд мэргэжлийн ёс зүйд холбогдох бүх нэр томьёог багтаах боломжгүй бөгөөд бүхэлдээ мэргэжилтнүүдэд санаа сэдэл өгөхөд чиглэгдэж буй.

Манай улсад мэргэжлийн ёс зүйн судалгаа тодорхой хэмжээнд хийгдэж ирсэн бөгөөд зарим мэргэжлийн ёс зүйн гарын авлага, сурах бичиг, цөөн тооны эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, нэр томьёоны тайлбар толь хэвлэгдэж нийтийн хүртээл болжээ. Төслийн багаас мэргэжлийн ёс зүйн нэр томьёоны товч тайлбар толийг хэвлүүлж байгаа нь хэрэглээний ёс зүйн салбарын нэр томьёо судлалд чухал ач холбогдолтой болж байна.

Ч.БАЯРЧИМЭГ
Д.ОЮУНГЭРЭЛ

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН
ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁОНЫ
ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

УЛААНБААТАР
2024

Зураг 30. “Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томьёоны товч тайлбар толь”
бүтээлийн хавтас

ДҮГНЭЛТ

“Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” төслийн үр дүнгийн даалгаврын биелэлт, хийсэн ажлуудаа дараах байдлаар багцлан дүгнэлт хийв.

Үүнд: а) мэргэжлийн ёс зүйн талаар судалгааны үр дүн, б) мэргэжлийн ёс зүйг хангах хууль, дүрмийн хэрэгжилт, в) мэргэжлийн ёс зүйн сургалтын үр дүн, үйл явцыг зохион байгуулах арга зүйд дэмжлэг үзүүлэх г) мэргэжлийн ёс зүйн зөвлөмж боловсруулах д) судалгааны үр дүнг сурталчлах зэрэг болно.

Нэгдүгээрт, мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг багш мэргэжлийн хүрээнд судлан гаргаж, түүнд шинжлэх ухааны үндэслэлтэй бодитой үнэлэлт дүгнэлт өгч цогц байдлаар хандаж, нэг сэдэвт бүтээл бичсэн нь энэ төрлийн судалгааны ажилд тодорхой хувь нэмэр болно хэмээн үзэж байна.

Хоёрдугаарт, багш мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, “Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” нэгэн сэдэвт бүтээл туурвиж, сургалт, судалгааны эргэлтэд оруулсан нь судлаач, оюутнуудын төдийгүй нийгмийн ёс суртахууны төлөв байдлыг сайжруулахад бага боловч нөлөө үзүүлнэ хэмээн үзэж байна.

Гуравдугаарт, төслийн үр дүнд мэргэжлийн ёс зүйн тайлбар толь бичих ажил бүрэн хэрэгжсэн бөгөөд энэ нь багш судлаач, мэргэжлийн хүрээнийхэн төдийгүй, байгууллага хамт олон, аж ахуйн нэгжүүд өөрийн үйл ажиллагаанд авч хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр бүхий бүтээл болсон.

Дөрөвдүгээрт, “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” бүтээл мэргэжлийн ёс зүйн онолын үндэс, их дээд сургуульд мэргэжлийн ёс зүй төлөвшүүлэхэд гадаад, дотоодын туршлага, мэргэжлийн ёс зүй хичээлийн хөтөлбөр, ажиллах жишээ зэргийг онцолж судалсан нь их дээд сургуулийн мэргэжлийн ёс зүйн хичээлийн чухал хэрэглэгдэхүүн болно хэмээн үзэж байна.

Тавдугаарт, төслийн үр дүнгийн даалгаварт тусгасан ёсоор ёс зүйн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид санал бодлоо солилцон, харилцан туршлагаа солилцсон нь тулгарч буй асуудалд шийдэл болох чухал ажил болсон.

Зургаадугаарт, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаанд мэргэжлийн ёс зүйн мэдлэг чадварыг олгох, хандлага төлөвшүүлэх асуудалд онцгой анхаарах

хэрэгтэй юм. Иймээс төслийн хүрээнд судалгаа хийх явцад МУИС-ийн багш бэлтгэх хөтөлбөрт “Багш мэргэжлийн ёс зүй” хичээлийн хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, шинэ хичээл заахаар болсон нь сургалтын үр дүн, үйл явцыг зохион байгуулах арга зүйд дэмжлэг үзүүлэх ажил болов.

Долдугаарт, мэргэжлийн ёс зүйг хангах хууль, дүрмийн хэрэгжилтэнд төслийн баг оролцож, тус ажилд онолын мэдлэг, ойлголтыг тайлбарлах, тулгарч буй асуудалд кейс жишээг тайлбарлах, онолын семинар зөвлөгөөнд илтгэл хэлэлцүүлэх зэргээр оролцов. Үүний үр дүнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ажлын дэд хэсгийн гишүүн, МУИС-ийн Багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрмийн өөрчлөлтийн ажлын хэсэгт ажиллаж тэдгээр хууль, дүрмийг батлуулахад гар бие оролцсон нь төслийн үр дүнгийн нэгэн хэрэгжилт хэмээн үзэх үндэстэй.

Наймдугаарт, “Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага” нэг сэдэвт бүтээлд зөвлөмж боловсруулж нийтлүүлсэн нь мэргэжлийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, ёс зүйн зөрчлөөс үүдсэн нийгмийн хор хохирлыг бууруулахад нөлөөлнө хэмээн дүгнэж байна.

Эцэст нь төслийн үр дүнг олон нийтэд хүргэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн ёс зүйн асуудлыг үндэсний хэмжээнд мэргэжлийн баг бүрдүүлэн илүү дэлгэрэнгүй судалж, өргөн хэмжээнд гүнзгийрүүлэн судлах шаардлагатай хэмээн төслийн баг дүгнэж байна.

Судалгааны илтгэлийн жагсаалт

Дотоодын эрдэм шинжилгээний хуралд:

1. Баярчимэг Ч. “Ёс зүй цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” (2021) хуралд “Цар тахлын үеийн багшийн үйл ажиллагаа. Гадаад дотоодын хэвлэлийн мэдээнд тулгуурлав” сэдэвт илтгэл,
2. Баярчимэг Ч. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” (2022) хуралд “Цахим эрин дэх багшийн дүр төрх” сэдэвт илтгэл,
3. Золзаяа М. Хиймэл оюун ухааны ёс зүй: сорилт ба хариуцлага. -“Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: философи асуудлууд”. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. УБ.,2020.
4. Золзаяа М. Нийгмийн тэгш бус байдлыг дискурсив ёс зүйн үүднээс шинжлэх нь. –Олон нийтийн дискурс дэх философийн үүрэг. ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. УБ.,2021. 68-73 дахь тал.
5. Золзаяа М., Дарьхүү Р. Ёс зүй ба боловсрол. //2022. 06-р сарын 20-ны өдөр. Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийн хаалтын 4-р салбар хуралдаан.
6. Золзаяа М, Дарьхүү Р. Ёс зүйг сэтгэл судлал мэтээр ойлгохуйг залруулах нь. //Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага. ЭШХ-ын эмхэтгэл. УБ.,2022. 41-52 дахь тал.
7. Золзаяа М, Р.Дарьхүү, Оюунгэрэл Д. Өнөөгийн нийгмийн ёс суртахууны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. “Өнөөгийн монголын нийгмийн ёс суртахууны өөрчлөлт, хандлага” сэдэвт хэлэлцүүлэг. Улаанбаатар, Төрийн ордон, 2023 оны 10-р сарын 09-ний өдөр.
8. Оюунгэрэл Д. “Ёс зүй цар тахлаас үүдэх сургамж ба алсын хараа” (2021) хуралд “Утилитар онолын үүднээс хэрэглээний ёс зүйн зарим асуудлыг тайлбарлах нь” сэдэвт илтгэл,
9. Оюунгэрэл Д. “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” (2022) хуралд “Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага” сэдэвт илтгэл,
10. Оюунгэрэл Д. Хүүхдэд ёс суртахууны боловсрол олгох чухал хэрэгсэл кино болох нь. Гоо зүйн боловсрол ба орчин үе. Улаанбаатар. 2022.05.12
11. Оюунгэрэл Д. “Бодь мөрийн зэргийн сургаал – орчин үед” хуралд “Бодь мөрийн зэрэг зохиол багшийн ёс зүйн тухай” сэдэвт илтгэл. (2023)

Б. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд:

1. Баярчимэг Ч, Золзаяа М, Оюунгэрэл Д. Хэл, соёл, боловсролын тулгамдсан асуудал. (2021) хуралд “Монголын хэвлэл мэдээлэлд багш мэргэжлийн ёс зүйн талаар туссан нь” сэдэвт илтгэл.
2. Оюунгэрэл Д. Олон улсын монгол судлаач эрдэмтний XII их хуралд (2023) “To determine the ethical issues of civil servants based on several resources”. Улаанбаатар. 2023 оны 08-р сарын 9-14-ны өдөр.

Судалгааны өгүүллийн жагсаалт

1. Оюунгэрэл Д. Боловсролын зорилгын тухай зарим философичийн үзэл санаа. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. УБ.,2022
2. Оюунгэрэл Д. Багш мэргэжлийн ёс зүй: тулгамдаж байгаа асуудал ба шийдэх арга зам. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. УБ.,2023
3. Оюунгэрэл Д. Платоны “Агуйн ёгтлол” ба боловсрол. МУИС. Боловсрол судлал сэтгүүл. УБ.,2020

Төслийн явцын үр дүн ба нийгмийн соён гэгээрэл

1. Д.Оюунгэрэл. “Багш мэргэжлийн ёс зүйн тухай”. Өмнөговь аймгийн бүх сумдын нийгэм ухааны багш нарт. 2021 он /цахим болон танхимын сургалт/
2. Био ёс зүй, ёс зүйн сургалт. ЮНЕСКО. Улаанбаатар. 2021 оны 06 дугаар сарын 17. Их дээд сургуулийн ёс зүйн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад сургагч багшаар ажиллав.
3. Д.Оюунгэрэл. Багш нарт зориулсан ёс зүйн сургалт. ЮНЕСКО. Улаанбаатар. 2021 оны 10 дугаар сарын 12-15. Сургагч багшаар ажиллав.
4. Д.Оюунгэрэл. “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн зарим агуулгыг тодруулах нь. Өмнөговь аймгийн бүх сумдын нийгэм ухааны багш нарт. 2022 он /цахим, танхим/ Дараалсан 3 жилийн нийт 6 удаагийн сургалт.
5. М.Золзаяа. Мэргэжлийн болон судлаачийн ёс зүй. ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн. Zoom Meet. 2021.06.24.
6. М.Золзаяа. Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйн асуудал. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. ШУА-ийн Хүрээлэнгүүдийн 1-р байрны хурлын танхим Google Meet. 2021.10.18.
7. М.Золзаяа. Ёс зүй: багш мэргэжлийн ёс зүй. Нийслэлийн ЕБС-ийн 21-р сургуулийн багш нарт. 2022.05.05.
8. М.Золзаяа. Ёс зүй: монголчуудын ёс зүйн сэтгэлгээ. УДЭТ-ийн уран бүтээлч нарт. 2022.05.19.
9. Д.Оюунгэрэл. “Ёс суртахуун гэж юу вэ?” Нийслэлийн 44-р сургуулийн 10 дугаар ангийн сурагчдад. 2023.10.13
10. Д.Оюунгэрэл. “Төрийн албан хаагчийн ёс зүй”. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрдэм шинжилгээний ажилчдад зориулсан сургалт. 2023.11.13
11. М.Золзаяа. “Ёс суртахууны харилцаа: нөхөрлөл, шударга ёс, үүрэг” СУИС. 2023.12.12
12. Д.Оюунгэрэл. Ажлын байрны ёс зүй. Ажлын байрны дадлагажуулагчийн сүлжээ байгуулах 2 дахь удаагийн уулзалт. НХХЯ, ХБХХЕГ, Жайка. 2023 оны 12-р сарын 13 (Лхагва)

Хавсралт 4. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАРЫН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

№01/24

ШУА-ийн Бага чуулганд

Хүмүүнлэгийн ухааны салбарын Эрдмийн зөвлөлийн хурал 2024 оны 2 дугаар сарын 20-ний өдрийн 18.00 цагт МУИС-ийн TEAMS системд цахимаар хуралдав. Хуралд ХУС-ын Эрдмийн зөвлөлийн гишүүн профессор Ж.Урангуа, П.Дэлгэржаргал, Д.Сайнбилэгт, М.Отгонбаяр, Б.Алтангүл, Г.Нандинбилэг, Т.Отгонтуул, Л.Одонтуяа, дэд профессор Ш.Эгшиг, Д.Отгонтуяа, Б.Даариймаа, Д.Ундрах, Б.Чинзориг, Б.Дагзмаа, В.Павлов нар оролцов.

Профессор Ц.Баттулга гадаадад ажиллаж буй. Профессор Д.Заяабаатар, эрдмийн зөвлөлийн дарга доктор Н.Алтантөгс нар МУИС-ийн журам танилцуулах хуралтай тул чөлөө авав. Хурлын ирц 83,3%.

Хурлаар Философи, шашин судлалын тэнхимийн багш доктор Д.Оюунгэрэлийн удирдсан, БШУЯ-ны ШУТС-ийн санхүүжилттэй “Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” сэдэвт төслийн үр дүнг хэлэлцэв.

Хурлыг эрдмийн зөвлөлийн нарийн бичиг хөтлөн явууллаа. Тэрээр өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг товч танилцуулж ФШСТ-ийн багш, доктор Д.Оюунгэрэлийг удирдсан төслөө танилцуулахыг хүслээ.

Дэд профессор Д.Оюунгэрэл: БШУЯ-ны захиалгаар ШУТС-ийн санхүүжилттэй “Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” сэдэвт төсөл 2020-2023 онд хэрэгжиж дууссан юм. Тус төслийг миний бие удирдаж төслийн багийн судлаачаар ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор, дэд профессор М.Золзаяа, ХААИС-ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш доктор, дэд профессор Ч.Баярчимэг нар хамтран ажилласан бөгөөд ёс зүйн чиглэлээр судалгаа хийдэг туршлагатай баг бүрдүүлж ажилласан болно.

Тус төслийн зорилго нь мэргэжлийн ёс зүйн төлөвшил, өөрчлөлт, нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлс, тулгамдсан асуудал, цаашдын хандлагыг тодорхой мэргэжлийн ёс зүйн асуудлаар төлөөлүүлэн тайлбарлаж, төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, нийт иргэдэд шаардлагатай шинжлэх ухааны үндэстэй бүтээл, зөвлөмж гаргахад оршино. Төслийн санхүүжилт 44 сая төгрөг бөгөөд МУИС-ийн дансаар орж зохих ёсоор зарцуулж санхүүгийн тайланг цаг тухайд нь бүрэн хийж, төслийн мөнгийг зарцуулж дууссан.

Төслийн үр дүнгийн даалгаварт заасан ажлуудыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, хагас жилийн, жилийн эцсийн тайланг ШУТС-д тухай бүрт тайлагнаж ирсэн. Төслийн үр дүнгийн даалгаварт 6 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. (тайланд хавсаргаасан байв) Олон улсын эрдэм шинжилгээний хуралд төслийн судалгааны сэдвээр 4 илтгэл хэлэлцүүлж, судалгааны багийнхан нийт 8 өгүүлэл хэвлүүлж, эрдэм шинжилгээний 1 хурал зохион байгуулж, мэргэжлийн ёс зүйн тайлбар толь, нэг сэдэвт бүтээл бичиж хэвлүүлсэн.

Профессор Т.Отгонтуул: Оюунгэрэл багш та бүхэнд төслөө танилцууллаа. Мөн холбогдох баримт материал, номын эхийг TEAMS-файлс хэсэгт байрлуулсан тул урьдчилан танилцсан байх. Асууж тодруулах зүйл байвал асууна уу.

Профессор Г.Нандинбилэг: Энэ төсөл инновацын төсөл үү, суурь судалгааны төсөл үү? Хэрэв суурь судалгаа бол тодорхой нэг судалгааны шинэ шатанд хүрсэн, нэг сэдэвт зохиол бичих, эсвэл өндөр түвшний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх гэсэн шаардлага байдаг байх.

Дэд профессор Д.Оюунгэрэл: Суурь судалгааны төсөл. Нэг сэдэвт зохиол бичсэн. Тэр номын шүүмжлэгчээр ШУА-ийн Бага чуулганаас хоёр хүн томилсон гэсэн. Одоо бага чуулганаар орохдоо тэр хүмүүсийн шүүмжийг сонсоно. Тэгээд номдоо тусгана.

Дэд профессор Б.Чинзориг: Төслийн санхүүжилт хэд вэ? Төслийн үр дүнг хэр биелсэн гэж төслийн удирдагч үзэж байна вэ?

Дэд профессор Д.Оюунгэрэл: Нийт санхүүжилт 44 сая. Төсөл удирдагчийн хувьд төслийн үр дүнгийн даалгаварт заасан ажлыг бүрэн гүйцэтгэсэн тул амжилттай хэрэгжиж дууссан гэж бодож байна.

Профессор Д.Сайнбилэгт: Багшийн ёс зүйн зөвлөмж гаргана гэсэн байна. Тэгэхээр ерөнхий боловсрол, их дээд сургууль, хот, орон нутгийн гээд маш олон багш нар байгаа. Хэрхэн хамрагдсан бэ, өмнө ямар асуудал байгаад одоо ямар асуудалд анхаарч зөвлөмж гарч байгаа вэ, шинэлэг чухал санаа юу гарсан бэ?

Дэд профессор Д.Оюунгэрэл: Төслийн судалгааны хүрээнд бид дараах бүтээлүүдийг хэвлэсэн. 1. Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл. Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага. Ред.Г.Эрдэнэбаяр. УБ.,2023 Тото пресс. 2. Ч.Баярчимэг. Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага. Ред.Д.Оюунгэрэл. УБ.,2023 Тото пресс. 3. Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл. Ёс зүйн зарим нэр томъёоны тайлбар. УБ.,2023. Тото пресс. Эдгээр бүтээлдээ судалгааныхаа үр дүнг тусгаж, мөн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хууль батлуулах дэд ажлын хэсэгт гишүүнээр, МУИС-ийн "Багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм"-ийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж зөвлөмж, судалгааны шинэ санаа оноог тусгаж ажилласан.

Профессор П.Дэлгэржаргал: Төсөл хэрэгжих хугацаанд маш их судалгаа хийж үр бүтээлтэй ажиллажээ. Бага чуулганд танилцуулахдаа үр дүнгийн даалгаврын дагуу хийсэн ажлаа дурдах нь зүйтэй. Харин судалгааны явцад хийсэн бусад олон ажлаа нэмж тайлбарлаж болно. Тэгэхгүй бол хэтэрхий их олон зүйлийг дурдвал зарим хүн гол зүйлийг чинь ойлгохгүй өнгөрөх вий. Төслийн хугацаанд 7 өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна. Мэдээж энэ судалгааны үр дүнгүүд нэг сэдэвт зохиолд туссан байх. Бага чуулганаас хоёр эксперт томилсон юм байна. Номоо гаргахдаа тэдгээр хүмүүсийн санал дүгнэлтийг сайтар нягталж тусгах хэрэгтэй. Ажлыг сайжруулахад их тус нэмэр болдог. ШУТС-аас төсөл авч хэрэгжүүлнэ гэдэг амаргүй. Төслийн цалин гэж олигтой зүйл байхгүй.

Профессор Д.Сайнбилэгт: Манай эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж байгаа болохоор энэ төслийг анх авахдаа мөн манай зөвлөлөөр ч юм уу, тэнхимээрээ хэлэлцүүлсэн зүйл байна уу. Отгонтуул багшаас бас давхар асууж байгаа юм.

Профессор Т.Отгонтуул: ШУТС-д мэдүүлж байгаа төслийг эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээс илүү нэгж дээрээ, өөрөөр хэлбэл гүйцэтгэх байгууллага гэдэг талаасаа тэнхимдээ хэлэлцүүлээд тэр материалаа хавсаргаж өгдөг байсан. Өмнөх төслүүд мөн ийм зарчмаар явсан. Одоо ч бас төсөл мэдүүлэх гэж байгаа багш нартаа ингэж зөвлөж байгаа. Тэр төсөл тухайн тэнхимд харьяалагдаж хэрэгжиж байгаа учраас ингэж шийдэж ирсэн. Алтантөгс захирлаас мөн лавлаж асуусан. Харин төслийн үр дүнг эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж хаадаг. Мөн системд төслийн үр дүнг тооцож хаадаг.

Профессор Д.Оюунгэрэл: Төсөл мэдүүлэхдээ Дэлгэржаргал багшаас гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт авч байсан. Мөн төсөл шалгаруулахад очиж төслийн тухай танилцуулга хийсэн.

Профессор Д.Сайнбилэгт: Нэг сэдэвт зохиол дээр хоёр эксперт томилсон гэсэн. Тэр хүмүүсийн саналыг харуулж болох уу?

Профессор Д.Оюунгэрэл: Хоёр эксперт томилсон гэдгийг л мэдэхээс ямар хүн, ямар санал өгсөн тухайд нарийн зүйл мэдэхгүй. 4 дэх өдөр бага чуулганаар хэлэлцүүлэхэд тодорхой болох байх.

Профессор Ж.Урангуа: Оюунгэрэл багшид зөвлөхөд бага чуулганд ажлаа танилцуулахдаа сайн бэлтгэж илүү тодорхой, гол хийсэн судалгааны ажлаа үр дүнгийн даалгаврын дагуу танилцуулаарай. Ер нь манай МУИС-ийн багш нарын төслийн тайлан, судалгааны ажил их чамбай сайн хийсэн байдаг. Нэг сэдэвт зохиолоо эцсийн байдлаар сайн хянаж, экспертийн өгсөн санал шүүмжийг тусгаж янзлах хэрэгтэй.

Профессор Т.Отгонтуул: Дэлгэржаргал багш бид бас ШУТС-ийн төсөл хэрэгжүүлж байсан. Бага чуулганд тайлагнахдаа яг үр дүнгийн даалгаврын дагуу биелэлтээ нарийн тодорхойлж ярих шаардлагатай юм билээ. Санхүүгийн тайланг ч бас хамгийн товч гол үзүүлэлтээр жил жилээр нь харуулж ярьсан. Нэг сэдэвт судалгааны бүтээлийг бид өмнө нь эрдмийн зөвлөлөөр хэлэлцэхдээ эхийг хэвлэсэн байдлаар танилцаж хэлэлцэж байсан. Энэ удаад Оюунгэрэл багш цаг давчуу хэлэлцүүлж байгаа тул юутай ч номын эхийг дэлгэцэд харуулах нь зүйтэй байх. Файлаар байрлуулсан тул та бүхэн нягтлан харах боломжтой. (нэг сэдэвт бүтээлийг дэлгэцэд харуулав)

Профессор Д.Сайнбилэгт: Багш нарын асуулт хариултаас ойлгохгүй байсан зарим зүйлээ ойлгочихлоо. Төслийг амжилттай хэрэгжсэн гэж дэмжиж байна.

Дэд профессор Ш.Эгшиг: Оюунгэрэл багшийн хийсэн ажлыг хангалттай гэж үзээд дэмжиж байна. Амжилт хүсье.

Профессор Г.Нандинбилиг: Төслийг дэмжиж байна. Төслийн үр дүнгээ тодорхой танилцуулж сурахад нэг туршлага болсон байх аа.

Дэд профессор Д.Отгонтуяа: Багш нартай санал нэг байна. Дэмжиж байна.


Дэд профессор Д.Ундрах: Оюунгэрэл багшийн төслийг амжилттай хэрэгжүүлэх тийм ч амар биш. Манай сургуулийн багш ШУТС-ийн төсөл хэрэгжүүлж байгаад талархууштай байна. Манай эрдмийн зөвлөл энэ төслийн ажлыг анхнаас нь хянаж, шалгаагүй, ажлын явцыг нь ШУТС өөрөө хянаж, тайлан авч, шинжээч томилж даалгавруудаа шалгасан юм байна. Суурь төслийн үр дүн болох бүтээлийг нь нэгэн сэдэвт бүтээл мөн эсэхийг, хаанаас зөвшөөрөл авсан, яаж шалгарсан зэргийг бид хэлэлцэж шүүх субъект биш гэж би бодож байна. Д.Оюунгэрэл багшийн эрдмийн зөвлөлд ирүүлсэн тайлангаас үзэхэд төслөөр хэрэгжүүлсэн даалгаврууд нь бүрэн биелсэн гэж харагдаж байна. Тэгэхээр Д.Оюунгэрэл багшийн ирүүлсэн тайланд үндэслээд энэ төслийг амжилттай хэрэгжүүлсэн гэж үзээд дэмжих саналтай байна.

Дэд профессор В.Павлов: Төслийг амжилттай хэрэгжсэн гэж үзээд саналыг дэмжиж байна.

Профессор Б.Алтангүл: Багш нартай санал нэг байна. Дэмжиж байна.

Хурлаас шийдвэрлэсэн нь: МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш доктор Д.Оюунгэрэлийн удирдсан, БШУЯ-ны ШУТС-ийн санхүүжилттэй “Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” сэдэвт суурь судалгааны төслийн үр дүнг эрдмийн зөвлөлийн гишүүд хэлэлцэж төслийг амжилттай хэрэгжүүлсэн хэмээн санал нэгтэй дэмжив.

ХУС-ын эрдмийн зөвлөлийн дарга  доктор Н.Алтантөгс

Эрдмийн зөвлөлийн нарийн бичиг  доктор Т.Отгонтуул

“Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” сэдэвт захиалгат төслийн ажилд өгөх судлаачийн дүгнэлт

ШуСС-2020/40 гэрээний дугаартай төслийн ажлыг танилцуулсан удиртгал, зохион байгуулсан хурал, хэлэлцүүлсэн илтгэлүүд, хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, ном сурах бичгийн жагсаалт, зөвлөж оролцсон хууль дүрэм, хийсэн сургалт лекц, эх сурвалжийн хөрвүүлэг гэсэн хэсгээс бүрдсэн тайлангийн материал хүлээн авсан. Төслийн үр дүнгийн биелэлт хоёр хуудастай.

1. Тайлангийн ажлын бүтэц, агуулга.

Тайлангийн удиртгал хэсэгт бичсэнээр төслийн үндсэн зорилго болох “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, өөрчлөлт, нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдсан асуудал, цаашдын хандлагыг тайлбарлан, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон нийт иргэдэд зориулсан шинжлэх ухааны үндэстэй санал, зөвлөмж гаргах” тус ажлыг 3 гишүүнтэй судалгааны баг, МУИС өмчлөгч байгууллага болж 2020-2023 оны хооронд хийж гүйцэтгэжээ. Төслийн хүрээнд “багшийн ёс зүй” хэмээх тухайлсан сэдвийн хүрээнд өнөөгийн монголын багшийн харилцааны ёс зүй, соёл, багшийн нийгмийн дүр төрх, багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг хариуцлагыг тодорхойлж тулгамдсан асуудал, холбогдох зөвлөмжийг боловсруулахаар эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, илтгэл, өгүүлэл, ном, сурах бичиг тэргүүтэн судалгааны бүтээл, практик зөвлөмжийг тусгасан томоохон багц ажлыг хэрэгжүүлсэн байна. Төслийн үндсэн цөм хэсэг нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулсан, тухайлбал нийслэлийн бүх дүүргүүд, Хангайн бүс- Дархан-Уул, Орхон, Төв; Говийн бүс- Дорноговь; Зүүн бүс- Хэнтий; Баруун бүс- Ховд, Баян-Өлгийн бүс нутгийн багш нарыг хамруулсан социологийн судалгааг хийж гүйцэтгэнэ хэмээсэн байна. (Тайлангийн 10 дах талд). Судалгааны ажлын тайлан нь нэгтгэгдэн гарч амжаагүй, эсвэл зохих стандарт дагуу бичигдээгүй учраас эцсийн нэгдсэн тайлан дүгнэлт гараагүй байна.

2. Үр дүн хийгдсэн ажлууд.

Төслийн хүрээнд, гэр бүлийн ёс зүй, цар тахлын үеийн сургамж, даян дэлхийн шилжилтийн ёс зүйн сорилт, гоо зүй, гэр бүлийн боловсрол зэрэг сэдэв чиглэлээр эрдэм шинжилгээний 4-5 хурал хэлэлцүүлгийг амжилттай явуулж, эрдэм шинжилгээний өгүүлэл найм, нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, нэр томёоны толь тус бүр хэвлүүлж байгааг дурьджээ. Түүнчлэн холбогдох хуулийн ажлын дэд хэсэг болон МУИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулахад оролцон ажилласан байна.

3. Төслийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлын агуулга.

Тайлангийн нэгтгэлийн дийлэнх хэсэг бүхэлдээ төслийн хүрээнд хийгдсэн судалгааны илтгэлүүдийг хэвлэж оруулжээ. Иймд дотоод дах долоо, олон улсад тавигдсан дөрөв илтгэлүүдийг уншаад тухайн төслийн хүрээнд илрүүлэн судалсан үндсэн агуулгыг дараах

байдлаар онцлон тодотгож байна. “Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлыг гүйцэтгэхдээ

1. Багшийн харилцааны ёс зүй, соёлын асуудал
2. Багшийн нийгмийн дүр төрх ба цахим орчин
3. Багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг, хариуцлагын тухай

гэсэн гурван бүлэг бүхий 56 асуултаас бүрдсэн томоохон хэмжээний судалгаа явуулсан гэж ойлголоо. (Г.Эрдэнэбаяр, Д.Оюунгэрэл нарын “Сайн багшийн тухай ойлголт: Монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага” илтгэлд. Тайлангийн 52 дах талд). “Цахим эрин дэх багшийн дүр төрх” илтгэлээс үзвэл, судалгааны хүрээнд 1480 багш, сургуулийн удирдах ажилтан нарыг, үүнээс 13% нь СӨБ, 83.3 % нь ЕБС, 3.7% нь их дээд сургуулийн багш нараас хамрагдсан томоохон ажил болсон. (Тайлангийн 64 дэх талд)

Судалгааны ажлын төв нь сайн багш гэж хэн болох, хэрхэн тодорхойлох, багшийн харилцааны ёс зүйн асуудал болон багш мэргэжлийн нэр хүндэд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлсийг илрүүлэхэд чиглэгдсэн гэж харагдаж байна. (“Сайн багшийн тухай ойлголт: Монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага” илтгэлд. Тайлангийн 54-62 дах талд.) Багш мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг өндөр мэдлэгтэй байхын хамтаар харилцааны ёс зүй, харилцааны ур чадвар эзэмших, эрх чөлөөний мэдрэмж, үе хоорондын ялгаа, соёлын өөрчлөлт болохыг тодорхойлоод, түүний шалтгаан үндсийг нийгэм-эдийн засгийн хамаарал, хувь хүний хөгжил, хамт олон удирдлагын арга барил, хүний эрх-соёлын хүрээнд тодотгон судалжээ. Түүнчлэн багш мэргэжлийн нэр хүндэд эергээр нөлөөлөх хүчин зүйлсийг багш мэргэжлийн нийгэмд гүйцэтгэх онцгой үүрэг, багшийн цалин, нийгмийн хангамжийг нэмэгдүүлэх, гэрийн сургаалын нөлөө, суралцагч, эцэг эхчүүдийн хүндлэлийг хүлээхэд анхааруулж, багш бэлтгэх тогтолцоо, багшийн мэдлэг, ур чадвар, ёс суртахуун асуудлыг сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс байгааг чухалчилсан байна. (“Багш мэргэжлийн ёс зүйн талаар туссан нь илтгэлээс” Тайлангийн 103-106 дах талд)

4. Төслийн ажлын арга зүй, үнэ цэн.

Манай эрдэмтэн судлаачдаас монголчуудын ёс зүйн сэтгэлгээний түүх, ёс зүйн онол үнэлэмж, өөрчлөлтийн судалгааг нэлээд дэлгэрэнгүй хийж ирсэн. Сүүлийн жилүүдэд мэргэжлийн болон хэрэглээний ёс зүйн талаар ШУА-ын Философийн хүрээлэн, МУИС-ын ШУС зэрэг судалгаа, сургалтын байгуулагаас чамгүй их ажил, хурал, сургалтуудыг зохион байгуулсан. Эдгээр ажлыг манлайлан хэрэгжүүлдэг эрдэмтэн судлаачид тус төслийн багт оролцож ажилласан нь тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд, ерөөс ажлын чанар үр дүнг тодорхойлоход чухал давуу тал болсон нь харагдана. Ялангуяа багшийн мэргэжил, үүрэг хариуцлага, нэр хүнд, ёс суртахууны асуудлыг философи-социологи- ёс зүйн онол арга зүйн хүрээнд судалгааны том олонлог өгөгдөлтэйгээр гурван өөр байгууллагын гурван судлаач Ковид цар тахлын үеийн цаг үеийн хүндрэлтэй нөхцөлтэй давхцан хэрэгжүүлсэн нь амаргүй

том сорилт, ачаалал, туршлага байсан нь лавтай. Мэргэжлийн ёс зүйн асуудал бол хувь хүний ухамсар, үнэлэмж төдийгүй, мэргэжлийн нэр хүнд, мэргэжлийн үүрэг, хариуцлага, үнэт зүйлсийг нэгтгэн ёс суртахууны өндөр шалгууруудыг багтаасан, гадаад дотоод, шууд ба дам нөлөөлөл ихтэй, судалгааны олон талт нарийн төвөртэй чиглэл. Төсөл хэрэгжүүлсэн үе нь цахим хийгээд бодит ахуйд хосолсон хүмүүсийн ёс суртахууны илрэл, хувирал, цочролтой, өнөөгийн манай нийгэм-соёлын үнэлэмж, боловсролын системийн шилжилт, иргэншил-хүмүүжлийн хаус нөхцөл дунд багш хэмээх тусгайлсан мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудлыг тухайлан судлан үзэж, хэлэлцүүлэг судалгааны олон ажил хийгдсэнээрээ давуутай, талархууштай болсон. Тиймээс нэн эрэлттэй болж буй мэргэжлийн ёс зүйн сэдвийг шинжлэх ухаан хүмүүнлэгийн онол арга зүйн ултай судалгаагаар ахиулан гүнзгийрүүлж, өөр өөр мэргэжлийн ёс зүйн асуудлыг цааш нь үргэлжлүүлэн судлах боломжтой онол-практикийн хийгээд арга зүй-үнэлэмжийн ач холбогдолтой ажил болсныг онцлон тэмдэглэе.

Дэвшүүлэн тавьсан зорилго, хамрах хүрээ нэн өргөн тул төслийн агуулга багтаамж, аргачлалын хувьд амаргүй байсан авч цаашдын онол-арга зүйн боловсруулалт, үргэлжлэх судалгаанд анхаарах боломжтой цөөн санал хэлье. Багшийн харилааны асуудал бол нийгэм, хамт олон, эцэг эх, суралцагчийн олон дэд бүлгийн хамаарал дундаас хэлэлцэгдэх сэдэв. Тус судалгаа бол багшийн ёс зүйн асуудлыг гагцхүү багш нар өөрсдөө тодорхойлсоноороо онцлогтой харагдана. Судалгаанд гол дата үндэслэл болгож буй зарим үзүүлэлт нь тухайн мэргэжлийн ёс зүйн шууд тодорхойлогч болох эсэхийг цаашид өргөжүүлэн үзвэл чухалтай. Жишээ нь судалгаанаас үзвэл, сайн багш, ёс зүйтэй багш хэмээхийг зөв харилцаатай байх (40.6%), суралцагчтай зөв харилцах (28.8 %) хэмээх үзүүлэлтээр тодорхойлсон нь магадгүй илүүтэй байгуулагын ёс зүйн үнэлэмжийг илэрхийлэгч үзүүлэлт байх үндэстэй. Тодорхой сургууль хамт олны дундах багш ба ер нь “багш” (сургууль хамт олноос гадна багш хэмээх ментор, коуч, хувиараа заагч) хэмээх мэргэжлийн ёс зүйн онтологи үнэлэмжийг нарийвчлах шаардлага бий. Олон улсын судалгаанаас үзэхэд, багшийн харилцааны асуудлыг хамт олон бусад багш нарын үнэлэмжээс илүүтэй суралцагч, эцэг эх, нийгмийн янз бүрийн бүлгүүдээс санамсаргүй түүвэр аргуудаар түлхүү хэрэглэн судалж буйг анхаарахгүй өнгөрөх ёсгүй. Төслийн хүрээнд багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг тодорхойлох суурь ойлголт, хэмжүүрүүдийг хэлэлцсэн илтгэл байгаа нь тун сайшаалтай. Цаашид улам нарийвчилсан философи дүгнэлт өгч цаад учир хамаарлыг харьцуулсан, ёс зүйн эрдмийг тухайлан гаргах нь зүйтэй. Тухайлбал, багшийн эрхэм чанар (dignity), багшийн үнэнч цэгц байдал (truthfulness), багшийн тэгш шударгуу байдал (fairness), багшийн эрх чөлөөт байдал ба хязгаар зэрэг язгуур категориудыг багш -хамт олон, багш- суралцагч, багш-эцэг эх зэрэг дэд бүлэг хоорондын харилцаан дунд тусгайлан гаргаж, өнөөгийн боловсрол сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд илэрч буй нийгэм-эдийн засаг, соёлын олон талт объектив субъектив нөхцөл шалтгаан дунд хөөн хэлэлцэж, хээл хахууль, хөрөнгө чинээ, ашиг хонжоо, нийгмийн гарал, байдал, нэр төр, үндэс угсаа, үзэл бодлын ялгаралаас үл хамаарч ажиллах багш мэргэжлийн ёс суртахууны шаардлага, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээний цогцыг хэрэгжих арга механизмын дагуу даацтайгаар дэвшүүлэн тавихыг хүсье.

Үүний нэг илэрхийлэл Монголын багш нарын нийтлэг ёс зүйн код, дүрмийг боловсруулах явдал байж магадгүй. Энэ бүхэн тус ажлын ач холбогдол, эрэлт хэрэгцээний чухлыг тодотгох үүднээс илэрхийлсэн санаа болно.

5. Дүгнэлт

Хөл хөдөлгөөн хориотой амаргүй үед төслийн хүрээнд тавьсан зорилго зорилтоо хэтэрхий цөөн судлаач харин ч хангалттай хэрэгжүүлж, олон ажлуудыг хийсэн байгааг анхааран тэмдэглэе. Харин төслийг бүхэлд нь нэгтгэн гаргасан төслийн судалгааны эцсийн тайланг зохих шаардлагын дагуу бичиж, төслийн товч агуулга, социологийн судалгааны үр дүн, дүгнэлтийг бүрэн хамруулан тайлагнах шаардлагатай. Түүнчлэн төслийн хүрээнд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн нэг сэдэвт бүтээл, мэргэжлийн ёс зүйн тайлбар толь тэргүүтэнээ хэвлүүлэн, төслийн техник ажиллагааг чамбайруулан сайжруулсаны эцэст ШУТ Санд хүлээлгэх өгөх нь зүйтэй байх гэж үзэж байна.

Дүгнэлт гаргасан



Бага Чуулганы гишүүн Д.Гантөмөр (Sc.D)

“МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ” СЭДЭВТ 2020-2023 (ШУСС-2020/40) ЗАХИАЛГАТ ТӨСЛИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас захиалсан “Мэргэжлийн ёс зүй” сэдэвтэй захиалгат судалгааны ажлын үр дүнг тоймлон авч үзэхэд, уг ажлыг хийж гүйцэтгэсэн судалгааны багийн ахлагчийн тайланд бичсэнээр “бүрэн хэрэгжсэн” хэмээн тайлагнажээ.

Уг ажлыг харьцангуй цөөхөн буюу Д.Оюунгэрэл, М.Золзаяа, Ч.Баярчимэг гэсэн гурван судлаач хийж гүйцэтгэсэн болох нь харагдаж байна. 2022 оныг БШУЯ-аас салбарын ёс зүйн жил болгон зарласан нь энэхүү ажлыг хийж гүйцэтгэх үетэй таарсан онцлог ч ажиглагдаж байна.

Судалгааны таамаглалдаа “Мэргэжлийн ёс зүй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, практикт нэвтрүүлснээр нийгмийн ёс суртахууны төлөв байдлыг сайжруулахад нөлөөлнө. Тодорхой мэргэжлийн ёс зүйг хангах хууль, дүрмийн хэрэгжилт, сургалтын үр дүн, үйл явцыг зохион байгуулах арга зүйд дэмжлэг үзүүлэх зөвлөмжийг боловсруулж, мэргэжлийн ёс зүйн зөрчлөөс үүдсэн нийгмийн хор хохирлыг бууруулахад нөлөөлнө” хэмээн үзсэн боловч тэрхүү үндэслэлээ хэрхэн шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан болох нь бичиж хэвлүүлсэн илтгэлүүдийн сэдэв, судлаачдын хамтарч ажилсан байдлаас төдийлөн ажиглагдахгүй байна. Тухайлбал судалгааны багийн ахлагчийн оролцсон ажил үүрэг давамгайл мэт ажиглагдах боловч үндсэн сэдэв болох мэргэжлийн ёс зүйн сэдвээр Ч.Баярчимэг “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага”. Ред.Д.Оюунгэрэл. УБ.,2023 Тото пресс. гэсэн 135 хуудастай бүтээлийг ганцаараа бичсэн байна. Энэ мэт судалгааны багийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг оролцоо тэгш бус байсан байж болох талтай.

Судалгааныхаа зорилго “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, өөрчлөлт, нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлс, тулгамдсан асуудал, цаашдын хандлагыг тайлбарлаж, төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, нийт иргэдэд шаардлагатай шинжлэх ухааны үндэстэй санал, зөвлөмж гаргахад оршино” хэмээн заасан байх бөгөөд харин энэ чиглэлд нэлээд ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Гэхдээ мөн л багийн Ч.Оюунгэрэл бараг ганцаараа ажиллажээ.

Өнгөрсөн хугацаанд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” батлагдан гарсан явдал нь мэргэжлийн ёс зүйн асуудлыг илүү анхаарах нэг түлхэц болж байна. Яг одоогоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030) боловсруулах чиглэлд холбогдох байнгын хороо, ТАЗ, АТГ, ШУА-н төлөөлөл ажиллаж эхлээд байгаа билээ.

Хэдийгээр мэргэжлийн ёс зүй гэсэн ихээхэн ерөнхий нэртэй боловч уг ажил голлож багшийн ёс зүйн асуудалд анхаарсан хэмээн зорилгодоо задлан бичжээ.

Судалгаа нь БШУЯ-ны захиалгаар ШУТС-ийн санхүүжилттэйгээр МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш доктор Д.Оюунгэрэлийн удирдаж хийсэн ажил байх боловч чухам ямар байгууллагын нэр дээр хийсэн болон уг байгууллагын мэргэжлийн салбар тэнхим, сургуулийн эрдмийн зөвлөлөөр үр дүнг хэлэлцүүлсэн эсэх тухай нь огт тайлагнаагүй байна.

Нийт 5 эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан эсвэл зохион байгуулахад оролцсон гэж байгаа боловч яг мэргэжлийн ёс зүй эсвэл багшийн ёс зүйн асуудлаар өөрсдөө бие дааж үндсэн сэдвээрээ хурал зохион байгуулаагүй болох нь ажиглагдаж байна. Тухайлбал,

“Тэр бүлийн аз жаргалын үндэс сайн үйл болох тухайд”, “Утилитарист онолын үүднээс хэрэглээний ёс зүйн асуудлыг тайлбарлах нь”, “Цар тахлын үеийн багшийн үйл ажиллагаа”, “Хүүхдэд ёс суртахууны боловсрол олгох чухал хэрэгсэл кино болох нь”, “Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага”, “Цахим эрин дэх багшийн дүр төрх”, “Өнөөгийн нийгмийн ёс суртахууны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”, “Бодь мөрийн зэрэг зохиол багшийн ёс зүйн тухай” гэх мэт сэдэвтэй илтгэлүүд хэлэлцүүлсэн байх ажээ. Хэдийгээр энэ бүхэн нь ёс зүйн асуудал мөн боловч зарим сэдвүүд мэргэжлийн ёс зүй гэх үндсэн асуудалд шууд чиглээгүй.

ОУЭШХ-д ч гэсэн “Монголын хэвлэл мэдээлэлд багш мэргэжлийн талаар туссан нь” , “Features of ethics of Mongolian family” “Буддын сургаалын алсын хараа ба био ёс зүйн асуудал”, “To determine the ethical issues of civil servants based on several resources” Төрийн хүний ёс суртахууны тухай зарим сурвалжаас тодруулахуй”, “Буддист мета ёс зүй дэх нэр томъёог судлах арга зүйн асуудал” сэдэвт илтгэл өгүүллэг хэвлэгдсэн байна.

Харин Д.Оюунгэрэлийн хувьд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн төслийн дэд ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж, тус хуулийг УИХ-аар батлуулсан. Тус төслийн нэгэн авч үзэх хэсэг бол төрийн албан хаагчийн ёс зүйн тухай байсан бөгөөд ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангах, нэр томъёо тайлбарлах, илтгэл хэлэлцүүлэх, улмаар хуульд тусгах зэргээр хамтарч ажилласан зэрэг үр дүн бүхий ажлууд энэ хугацаанд хийж гүйцэтгэсэн болохыг сайшааж байна. Харин гол бүтээл нь “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” “Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал” нэртэйгээр одоо хэвлэгдэнэ гэж үзвэл уг төсөлт ажил үндсэн зорилгодоо хүрсэн хэмээн үзэж болох юм. Гэвч үр дүнгийн батлагдсан хавсралттай нь тулгаж хараагүй, байхгүй байсан гэдгийг онцлон тэмдэглэе.

Шүүмж бичсэн ШУА-н Хүмүүнлэгийн салбарын бага чуулганы гишүүн, Философийн ухааны доктор, профессор Б.Пүрэвсүрэн

Улаанбаатар 2024.02.22.

Хавсралт 6. Шинжээчийн дүгнэлтийн мөрөөр хийсэн засвар

**ШУА-ИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАРЫН БАГА ЧУУЛГАНЫ 2024 ОНЫ 2
ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН
Д.ОЮУНГЭРЭЛ УДИРДАГЧТАЙ “МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТУЛГАМДСАН
АСУУДАЛ” СЭДЭВТ СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАНД ӨГСӨН САНАЛ,
ШҮҮМЖИЙН МӨРӨӨР ХИЙСЭН ЗАСВАР**

№	Бага чуулганаас болон төслийн тайлангийн шинжээчийн санал, шүүмж	Санал, шүүмжийн гүйцэтгэл
1	Социологийн судалгааны үр дүн, дүгнэлтийг хамруулан тайлагнах	Багш мэргэжлийн ёс зүйн өнөөгийн байдал социологийн судалгааны дүнг тайланд тусгав.
2	Мэргэжлийн ёс зүйн тайлбар толийг хэвлүүлэн ШУТСанд хүлээлгэн өгөх	“Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь” хэвлэгдсэн ШУТС -д хүлээлгэн өгөхөд бэлэн болсон
3	Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн тухай тайланд дурдаагүй байна.	МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж амжилттай хэрэгжсэн дүгнэлтийг тайлангийн хэсэгт оруулав.
4	Эцсийн тайланг зохих стандартын дагуу бичих	БАРИМТ БИЧИГ - ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН. БҮТЭЦ, ШААРДЛАГА MNS 2492 : 2004 -гийн дагуу бичив.
5	Төслийн үр дүнгийн даалгаварт тусгасан зүйлийг бүрдүүлэн хүлээлгэн өгөх	“Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага”, “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, хандлага” бүтээлүүд Бага чуулганы хэлэлцүүлгийн үед бэлэн байж, чуулганы гишүүд танилцсан болно. Харин “Мэргэжлийн ёс зүйн түлхүүр нэр томъёоны товч тайлбар толь” хэвлэгдээгүй байсан бөгөөд эхийг танилцуулсан. ШУТС-д хүлээлгэж өгөхөд бэлэн болов.
6	Багш мэргэжлийн ёс зүйгээр хурал хийсэн эсэх нь тодорхой бус	2022 онд зохион байгуулсан “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” эрдэм шинжилгээний хурал нь 4 дэд салбараар явагдсаны 1-р салбар хуралдаан “Боловсролын ёс зүй” гэсэн нэрээр явагдсан болохыг тайланд тусгасан. Тус 1-р салбар хуралдааны 6 илтгэл нь багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг хөндөж тавьсан болно. Хурлын эмхэтгэлийн дотор нүүрэнд тус хурал нь “Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал” төслийн хүрээнд, тус төслийн

	санхүүжилтээр зохиогдсон болохыг тэмдэглэсэн.
--	---

ТӨСЛИЙН УДИРДАГЧ: /Д.Оюунгэрэл/

ХҮЛЭЭН АВСАН:

ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын

бага чуулганы дарга академич Л.БОЛД

ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулганы

Эрдэм нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) А.АМАРСАНАА

Хавсралт 7. ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын
Бага чуулганы хурлын тэмдэглэлээс



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАРЫН
БАГА ЧУУЛГАН

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулган 2024 оны 2 дугаар сарын 22 өдөр 10-15.10 цагт хуралдав.

Хуралд оролцсон: Академич Л.Болд, Д.Төмөртоого, Б.Чулуундорж, Ц.Батбаяр, С.Чулуун, Ч.Ган-Өлзий, доктор (Sc.D) Ц.Цэрэндорж, Ш.Ариунаа, С.Байгалсайхан, Ц.Өнөрбаян, Ц.Эрдэнэцог, Д.Гантөмөр, доктор (Ph.D) Б.Пүрэвсүрэн, Н.Хишигт, О.Шинэбаяр, М.Золзаяа, Л.Чойжилмаа, Я.Төмөрбаатар, С.Цэдэндамба, Г.Эрэгзэн, Л.Эрдэнэболд нар оролцов.

Өвчтэй - академич Ж.Болдбаатар, Д.Цэрэнсодном, чөлөөтэй - Х.Сүглэгмаа
Ирвэл зохих 25 гишүүнээс Өвчтэй 2, чөлөөтэй 1, ирсэн 21 гишүүн. Хурлын ирц 95%-тай бүрдсэн.

Хурлыг бага чуулганы дарга, академич Л.Болд удирдан явуулав.

Хэлэлцэх асуудал:

2020-2023 онд хэрэгжиж дууссан Суурь судалгааны төслийн 4 тайлан хэлэлцэж, дүгнэлт гаргах

Хэлэлцсэн нь:

“МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ” Монгол Улсын Их сургууль, Удирдагч: доктор (Ph.D), профессор Д.Оюунгэрэл

Төслийн тайланг төслийн удирдагч доктор (Ph.D), профессор Д.Оюунгэрэл 15 минут илтгэн танилцуулав: - Төслийн зорилго “Мэргэжлийн ёс зүйн төлөвшил, өөрчлөлт, нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдсан асуудал, цаашдын хандлагыг тайлбарлан, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон нийт иргэдэд зориулсан шинжлэх ухааны үндэстэй санал, зөвлөмж гаргах” тус ажлыг 3 гишүүнтэй судалгааны баг, МУИС өмчлөгч байгууллага болж 2020-2023 оны хооронд хийж гүйцэтгэжээ. Төслийн хүрээнд “багшийн ёс зүй” хэмээх тухайлсан сэдвийн хүрээнд өнөөгийн монголын багшийн харилцааны ёс зүй, соёл, багшийн нийгмийн дүр төрх, багш мэргэжлийн нэр хүнд, үүрэг хариуцлагыг тодорхойлж тулгамдсан асуудал, холбогдох зөвлөмжийг боловсруулахаар эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, илтгэл, өгүүлэл, ном, сурах бичиг тэргүүтэн судалгааны бүтээл, практик зөвлөмжийг тусгасан томоохон багц ажлыг хэрэгжүүлсэн. Төслийн үндсэн цөм хэсэг нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулсан, тухайлбал нийслэлийн бүх дүүргүүд, Хангайн бүс- Дархан-Уул, Орхон, Төв; Говийн бүс Дорноговь; Зүүн бүс- Хэнтий; Баруун бүс-Ховд, Баян-Өлгийн бүс нутгийн багш нарыг хамруулсан социологийн судалгааг хийж гүйцэтгэв.

Төслийн хүрээнд, гэр бүлийн ёс зүй, цар тахлын үеийн сургамж, даян дэлхийн шилжилтийн ёс зүйн сорилт, гоо зүй, гэр бүлийн боловсрол зэрэг сэдэв чиглэлээр эрдэм шинжилгээний 4-5 хурал хэлэлцүүлгийг амжилттай явуулж, эрдэм шинжилгээний өгүүлэл найм, нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, нэр томъёоны толь

тус бүр хэвлүүлсэн. Түүнчлэн холбогдох хуулийн ажлын дэд хэсэг болон МУИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрмийг боловсруулахад оролцон ажиллалаа.

Тайлангийн шинжээчид:

Доктор (Sc.D), профессор Д.Гантөмөр, Доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэн нарын дүгнэлтийг хавсаргав.

Асуулт хариулт, санал шүүмж:

Л.Болд: - За одоо хурлын дэгийн дагуу төслийн удирдагч болон төслийн шинжээчдээс асууж тодруулах зүйл байна уу?

Ш.Ариунаа: - Төслийн багаас асуулт асууя аа. Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал гэсэн байна. Энд юу юу болоод, ямар асуудал байна гэдгийг тодорхойлон гаргаж захиалагч байгууллагадаа санал болгосон бэ?

Д.Оюунгэрэл: - Анх энэ төслийг шалгаруулах комиссоор орж хэлэлцүүлэхдээ яг энэ асуудлыг хэлэлцэж байсан. Тухайн үед шалгаруулах комисс хэлэхдээ мэргэжлийн ёс зүйн асуудал гэж хэтэрхий өргөн хүрээтэй авч үзэж байна. Нэгээс хоёр л мэргэжлийг сонгож авч судалгаа хий гэж зөвлөж байсан. Тийм учраас тухайн үедээ бид нөхцөл байдлыг соргог анзаарч, судалгаа хийдэг хүмүүсийн хувьд багш мэргэжлийг сонгож авсан. Багш мэргэжлийн тулгамдсан асуудлыг яг юу болоод байна, ямар асуудал үүсээд байна, шалтгаан нь юу юм, түүн дээр ямар тайлбар хийх ёстой вэ гэдэг асуудлаар тухайн үед сонгож хийж байсан.

Түрүүн Б.Пүрэвсүрэн докторын санал дээр зарим нэг зүйлийг нэмж тайлбарлах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Нэгдүгээрт нь манай баг хэтэрхий цөөхөн хүнтэй нь үнэн, гуравхан хүнтэй том ажлын ард гарах гэж оролдож байна. Ерөнхийдөө багийн судлаачид жигд оролцсон. Баярчимэг багшийн хувьд мэргэжлийн ёс зүйн тухай нэг сэдэвт бүтээл хэвлэгдэн гарсан. Золзаяа доктор цэвэр онол арга зүйн хувьд нь биднийг дэмжиж чиглүүлж оролцсон том оролцоотой. Үүнийг бас тайлан дээрээ тодорхой нэмж бичье гэдэг бодолтой байна. Мөн түүнээс гадна миний бие ганцаараа “Мэргэжлийн ёс зүй” гэсэн 350 хуудастай бүтээлийг хэвлүүлэх гэж байгаа. Гэхдээ энэ ажил Үр дүнгийн даалгавар дээр байхгүй байгаа учир төдийлөн онцолж ярьсангүй. Тийм учраас Үр дүнгийн даалгавартай холбоотой хэсгээ л өнөөдөр ярья гэж бодсон. Гэхдээ хэвлүүлэхдээ Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал сэдвийнхээ хүрээнд хэвлүүлнэ гэдгээ онцолж хэлье.

Төслийн тайлангаа стандарт загварын дагуу бичих ёстой юм байна гэдгээ сайн ойлголоо. Бусад шинжээчдийн гаргасан саналыг дэмжиж байна.

Я.Төмөрбаатар: - Энэ үнэхээр нийгэмд тулгамдсан чухал асуудлыг БШУЯ захиалсан юм байна. Төслийн багийнхнаас гадна, төслийн тайлангийн шинжээч Б.Пүрэвсүрэн докторт талархал илэрхийлмээр байна. Яагаад гэвэл Б.Пүрэвсүрэн доктор үнэхээр голыг нь олж маш сайн чухал шүүмж өглөө гэж бодож байна. Тийм учраас төслийн удирдагч тайлангаа бичихдээ Б.Пүрэвсүрэн докторын өгсөн саналуудыг маш сайн анхаарч бичих нь зөв болов уу гэж бодож байна. Энэ төсөл бол миний яриад байдаг төрийн бодлогод зөвлөмж өгөх гэдэг дээр чухал акцент өгсөн. Маш олон оронд төрийн албаны ёс зүйг хуульчилсан байдаг. Зарим орнууд хуульчилдаггүй гэдэг талаар Б.Пүрэвсүрэн доктор хэллээ. Үнэхээр хуульчлах юм бол ёс зүй гэж байгаад яахын, тэгэхээр энэ жил чинь Төрийн албаны ёс зүйн хуультай болчихлоо. Боловсролын багц хууль гэж батлагдсан. Ерөнхий боловсролын сургуулиуд, эцэг эх сурагчид багш нар, цаг үетэйгээ уялдаад багш гэдэг тал руугаа нэлээд явсан юм шиг байна. Ажилт хүсье, баярлалаа.

Л.Болд: - Төслийн тайлангийн шинжээчид их сайн ажилласан гэж үзээд төслийн тайланг бага чуулганаараа хүлээж авах уу?

Суурь судалгааны төслийн тайланг хүлээн авах саналыг гишүүд дэмжлээ.


ШИЙДВЭРЛЭСЭН нь: ШУТТХ-ийн 8.1.6, ШУА-ийн эрхзүйн байдлын тухай хуулийн 5.5-ийн 1,2-ийг үндэслэн, **“МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”** суурь судалгааны төслийн үр дүнг хэлэлцээд:

1. Монгол Улсын Их сургуульд хэрэгжүүлсэн **“МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ”** сэдэвт суурь судалгааны төслийн баг судалгааны гэрээнд заагдсан үр дүнгийн даалгаврыг биелүүлсэн гэж үзэв.
2. ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулганы гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тайланд тусган сайжруулж ШУТС-нд хүлээлгэн өгөхийг Суурь судалгааны төслийн багийн удирдагчид даалгав.
3. Журмын дагуу холбогдох газарт тайлан хүлээлгэн өгөх ажилд хяналт тавьж ажиллахыг Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулганы Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) А.Амарсанаад үүрэг болгов.

Тайлбар: Тайланг стандартын дагуу бичиж, холбогдох засваруудыг оруулсан тул хүлээж авав.

Тэмдэглэлтэй танилцсан: ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулганы дарга, академич Л.Болд

Тэмдэглэл хөтөлсөн: ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулганы Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) А.Амарсанаа



Тайлан бичсэн..... Д.Оюунгэрэл, төслийн удирдагч,
доктор (Ph.D)

Талархал

Төслийн ажлыг дэмжиж хамтран ажилласан БШУЯ, санхүүжүүлж, явц дундын тайлан сонсож зөвлөгөө өгч ажилласан ШУТС-ийн мэргэжилтнүүд, төслийн тайлан хэлэлцэж буй эрдэмтэн судлаач, экспертүүд, социологийн судалгаанд оролцсон нийт хүмүүс, багш нар, мөн төслийн багийнхандаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.